

Оны Хуваалцах цагийн хөтөлбөр

ЗӨВИЙГ СОНГО

“Хэнд үйлчлэх вэ гэдгээ өнөөдөр өөрсдөө сонго, . . . харин би болон манай гэрийнхэн бид Их Эзэнд үйлчилнэ” (Иошуа 24:15).





Хуваалцах цаг болон ариун ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгын зааварчилгаа

Хүндэт Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн болон хөгжмийн удирдагч нар аа,

Энэ жил та бүхэнд зөвийг сонгохын ач холбогдлыг хүүхдүүдэд заах боломж олдож байна. Сайн сонголт хийж сурах нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг бөгөөд энэ нь бидэнд олон адислал авчрах болно. Энэ хөтөлбөрт орсон хичээллүүдийг заахдаа залбирч Их Эзэний Сүнснийг урихыг хичээ. Хэрэв ингэх юм бол хүүхдүүд Есүс Христийн жишээг болон сайн мэдээний зарчмуудыг дагаж, сонголт хийх үедээ Ариун Сүнсний өдөөлтүүдэд анхаарал тавихыг сурах болно. Зөвийг сонгох нь Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очих зам дээр үлдэхэд нь хүүхдүүдэд туслах болно.

Хүүхдийн Хэсгийнхээ хүүхдүүдэд зааж, тэднийг хайрлан, итгэлтэйгээр үйлчилдэгт тань бид талархдаг билээ. Бид та нарын төлөө залбирдаг бөгөөд энэхүү чухал дуудлагад үйлчилсний тань төлөө Их Эзэн та нарыг адисална гэдгийг мэднэ.

Хүүхдийн Хэсгийн Ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

Хуваалцах цагийн зааварчилгаа

Сайн мэдээний зааварчилгаа

Долоо хоног тутам заагдах хуваалцах цагийн 15 минутын хичээлийг бэлтгэхдээ энэхүү товхимлыг ашиглана уу. Сүмээс зөвшөөрөгдсөн *Найз* эсвэл *Лиахона сэтгүүлээс материал нэмж ашиглаж болно*. Дараах удирдамжууд хичээлээ төлөвлөж заахад тань тусална.

Заадаг хүүхдүүдээ хайрла. Хүүхдүүдийн сонирхол, авьяас билэг, хэрэгцээ шаардлагыг мөн тэдний нэрсийг мэддэг болсноор тэднийг хайрладгаа харуул.

Сургаалыг Сүнслэгээр заа. Хичээлээ бэлтгэх явцдаа заах зарчмуудынхаа талаар гэрчлэлээ бэхжүүлж, удирдамж хүлээн авахын төлөө залбир. Энэ нь Сүнслэгээр заахад тань туслана.

Суралцахад урь. Энэхүү товхимол нь танд зөвхөн юу заахыг хэлээд зогсохгүй *хэрхэн* заах болон хүүхдүүдийг хичээлд идэвхтэй оролцуулахад тань тусалж чадна. Дараах гурван зүйлийг хичээл бүр дээр хэрэгжүүлснээр та сургаалыг илүү үр дүнтэйгээр зааж чадна.

1. **Сургаалыг таньж мэдэх.** Хүүхдүүдийн сурах сургаалыг ойлгомжтойгоор заа. Хэл яриагаараа болон үзүүлэн ашиглах замаар

сургаалыг ойлгуулах аргуудыг хайцгаа. (Жишээ нь, Тавдугаар сарын гурав дахь болон наймдугаар сарын хоёр дахь долоо хоногийн хичээлийг үз.)

2. **Ойлголтыг нь урамшуулан дэмж.** Дуулах, жүжигчилсэн тоглолт хийж үзүүлэх, судруудаас унших зэрэг олон янзын арга хэлбэрээр заах нь сургаалыг гүнзгий ойлгоход хүүхдүүдэд тусалдаг учир эдгээр аргуудыг онцгойлон анхаар

3. **Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж.** Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэх боломжийг хүүхдүүдэд

олго. Тэд тухайн сургаалтай холбоотой зорилго тавих болон үүний талаарх мэдрэмжээ илэрхийлж сурахад нь анхаарал хандуул.

Энэ товхимолд энэ жилийн зарим долоо хоногт заагдах хичээлийг бүрнээр нь багтаасан болно. Бусад долоо хоногуудад бүрэн хичээллүүдийг бус зөвхөн санаануудыг оруулж өгсөн байгаа. Эдгээр

санаанууд дээр өөрийнхөө санааг нэмж баяжуулан ашиглаарай. Та энэхүү товхимолд багтсан зарим хичээлийг уншиж судлан санаа авах боломжтой. Тав дахь ням гарагт өмнө үзсэн хичээлдүүдээ давтан бататгаж болно.

Долоо хоног бүр
(1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө,
(2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал,
(3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал.



Интернетээс олж үзэх боломжтой

Зүйлс: Энэ гарын авлагад дурдсан мэдээлэл, үзүүлэн, эш татсан эх сурвалж материалуудыг интернетэд LDS.org-ын *Serving in the Church* хэсэгт байршуулсан байгаа.

Хичээлээ төлөвлөж, бэлтгэх үед чинь Сүнс таныг удирдан хөтөлнө.

Хичээлээ хөгжмийн удирдагчтай хамтран бэлтгэ. Дуу дуулах нь таны зааж буй сургаалыг тодотгож, баяжуулахад тань тусална. Та сайн мэдээний зарим хэсгийг заахдаа өөр ангийн багш, хүүхдүүдийг хичээлд оролцохыг урьж болно.

Зарим хичээлд Хүүхдийн Хэсэгт үг хэлэх зочин урихыг санал болгодог. Гэвч хэн нэгнийг урихынхаа өмнө бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө зөвшөөрөл авах хэрэгтэй.

Заах ур чадвараа сайжруулахад тань туслах хэд, хэдэн зөвлөгөө хичээлүүдэд орсон байгаа. Танд ойлгомжтой болгохын тулд тухайн хичээлийн үйл ажиллагааг харуулсан зургуудыг хичээлүүдэд багтаасан. Хэдийгээр заах ур чадвар чухал боловч таны сүнслэг бэлтгэл, гэрчлэл нь хүүхдүүдийн зүрх сэтгэлд

сургаалуудыг бататгаж өгөх Сүнсийг урьдаг билээ.

Дуу дуулах цаг

Хүүхдийн Хэсгийн дуу хөгжим нь хүндэтгэлтэй нам гүм орчныг бүрдүүлдэг. Бас сайн мэдээг заахад Ариун Сүнсээр болон дуу дуулснаар ирдэг баяр баяслыг мэдрэхэд нь хүүхдүүдэд тусалдаг юм. Хуваалцах цагийн 20 минутыг дуу дуулах болон шинэ дуу заахад зориулах хэрэгтэй. Энэ хугацаа нь шинэ дуу заах болон хүүхдүүд дуулснаар сайхан мэдрэмж хүлээн авах хангалттай цаг юм.

Энэ товхимолд энэ жил хүүхдүүдийн сурах ёстой шинэ дууг багтаасан (28-р хуудсыг үз). Түүнчлэн “Дуу хөгжмийг Хүүхдийн Хэсэгт хэрхэн ашиглах вэ” (26–27-р хуудсыг үз) гэсэн хэсгийг оруулж өгсөн мөн дуунуудыг хүүхдүүдэд заах нэмэлт санаануудыг багтаасан байгаа (9 болон 17-р хуудсыг үз).



Бэлтгэл: Хуваалцах цагаар заах бэлтгэлээ хангахдаа удирдамж болоод Сүнсний нөлөөг эрэлхийлэн залбир. Та Сүнсний нөлөөн дор бэлтгэн заахад Сүнс зааж буй зүйлсийн тань үнэнийг батлах болно. (TNGC, 13-г үз.)

Ариун ёслолын цуглаан дээр хийх танилцуулга–хөтөлбөрийн удирдамж

Ариун ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгыг жил бүрийн дөрөвдүгээр улиралд бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн удирдлаган дор хийдэг. Тухайн жилийн эхээр бишопын зөвлөл эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн Хүүхдийн Хэсгийг хариуцсан зөвлөлтэй уулзаж урьдчилсан төлөвлөгөөний талаар ярилцах хэрэгтэй. Төлөвлөгөөг гүйцэд хийсэн үедээ зөвшөөрлийг ав.

Хүүхдийн хөтөлбөрийг сар тутмын хуваалцах цагийн сэдвүүдэд тулгуурлан төлөвлөсөн байх хэрэгтэй. Танилцуулгын хөтөлбөрт ашиглах зорилгоор жилийн туршид хүүхдүүдийн яриа болон хувийн туршлагыг тэмдэглэн авч болно. Тухайн жилийн турш сурсан зүйлээсээ хүүхдүүд хуваалцах үед цугларагсад хүүхдүүдийн зааж байгаа сайн мэдээний сургаалд анхаарал хандуулахад нь туслах арга замыг бодоорой. Бишопын зөвлөлийн нэг гишүүн товч дүгнэлтийг хэлж, цуглааныг хаана.

Танилцуулгыг бэлтгэх явцдаа дараах удирдамжуудыг баримтал:

- Танилцуулгын бэлтгэл нь хичээл болон гэр бүлтэйгээ өнгөрүүлэх цагаас нь авахгүй байх ёстой.
- Үзүүлэн, хувцас өмсгөл, мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэргийг ариун ёслолын цуглаанд ашиглах нь зохисгүй юм.



Энэхүү товхимолд ашигласан эх сурвалж материалууд

Тус товхимолд дараах товчилсон үгсийг хэрэглэсэн болно:

ХДН Хүүхдийн дууны ном, СДБХД (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу)


TNGC *Teaching, No Greater Call*

Олон хичээлд зураг ашиглахыг зөвлөсөн байгаа. Та зургуудыг *Сайн мэдээний уран зургийн ном*, *Сайн мэдээний уран зургийн цуглуулга*, *Хүүхдийн Хэсгийн гарын авлагын зургийн цомгууд*, *Сүмийн сэтгүүлүүд* болон интернет дэх images.lds.org хаягаар орж авч болно.

Эх сурвалж материалууд: Заахад тань туслах материалууд тухайлбал будах хуудас, түүх, үйл ажиллагаанууд зэрэг нэмэлт эх сурвалжуудыг Найз, Лиахона, бага насны хүүхдийн ангийн гарын авлага, Сайн мэдээний уран зургийн цуглуулгаас авч болно. Эдгээр эх сурвалжуудыг хичээлдээ нэмэлт материал болгон ашигла. Мөн сайн мэдээний аль нэг сэдвээрх эх сурвалжийн материалуудын жагсаалтыг Найз болон friend.lds.org-аас олж болно. Хүүхдүүдэд заахдаа эдгээр эх сурвалжыг хэвлэн авч, ашиглаж болно.

Сонгох эрх бол өөрсдийнхөө төлөө сонгох бэлэг юм

Дуу: “Бурханы хүүхэд болохоор”
(энэ хөтөлбөрийн 28-р хуудас)



Судар ашиглах нь:
Сайн мэдээний үнэнүүдийг судруудаас мэдэх нь хүүхдүүдийн хувьд маш чухал юм. Хүүхдүүдэд судрын түүхийг хэрхэн заах тухай зарим санааг TNGC, 59-өөс үзнэ үү.

“Иймийн тул, хүмүүн нь . . . бүх хүмүүний агуу их Зуучаар дамжуулан эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эрхтэй” 2 Нифай 2:27

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**


Нэгдэх болон хоёрдахь долоо хоног: Сонгох эрх бол өөрсдийнхөө төлөө сонгох бэлэг юм.

Сургаалыг таниул (таах тоглоом тогло):

Та нэг үгний тухай бодож байна гэж хүүхдүүдэд хэлээд тэр үгийг таахад нь туслах санааг тэдэнд өг. Хариултыг мэдсэн үедээ гараа өргөхийг тэднээс хүс. Дөхүүлэх санаануудад дараах зүйлс орж болно: Дэлхийд ирэхээс өмнө энэ зүйл бидэнд байсан. Энэ бол бидний Тэнгэрлэг Эцэгийн бэлэг. Энэ бол бидэнд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг юм. Сатан үүнийг биднээс булааж авахыг хүссэн. Бид сонголт хийхдээ үүнийг ашигладаг. Энэ бол бидэнд өөрсдийнхөө төлөө сонгох боломж олгодог бэлэг. Энэ үг С үсгээр эхэлдэг. Хүүхдүүд хариуг таасны дараа, “Сонгох эрх бол өөрсдийнхөө төлөө сонгох бэлэг юм” гэж хамтдаа хэлнэ.

Ойлголтыг урамшуулан дэмж (үзүүлэнт хичээлийг үзэж, ярилц): Нэг үзүүрт нь сонголт нөгөө үзүүрт нь үр дагаврууд гэсэн хоёр үг бичсэн саваа модыг хүүхдүүдэд үзүүл. Үр дагавар гэдэг бол бидний хийсэн сонголтын улмаас


болон түүний үр дагаврыг хоёуланг нь өөртөө авах болно гэдгийг хэл. 2 Нифай 2:27-г уншихыг ахмад хүүхдээс хүс. Зөв сонголтын үр дагаврууд нь (эрх чөлөө болон мөнх амьдрал) юу байдгийг, мөн буруу сонголтын үр дагаврууд нь (боолчлол болон зовлон) юу болохыг мэдэхийн тулд анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс. Энд харуулсантай адил энгийн диаграммыг самбар дээр зур.



Бид сайн сонголт хийсэн үед уг сонголт эрх чөлөө, аз жаргал уруу хөтөлдөг харин бид буруу сонголт хийсэн үед энэ нь боолчлол болон аз жаргалгүй байдал уруу хөтөлдөг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Хоёр хүүхдийг ангийн урд гарч ирэхийг урьж, саваа модны хоёр үзүүрийг тэдэнд нэг нэгээр нь бариул. “Сонголт” гэсэн үзүүрээс барьж байгаа хүүхдээс сайн сонголтын нэг жишээ хэлэхийг хүс (жишээ нь, бусад хүмүүстэй ярихдаа эелдэг уриалгахан байх).

Нөгөө хүүхдээс уг сонголтын үр дагавруудыг хэлэхийг хүс (жишээ нь, бат бөх үерхэл нөхөрлөл). Ийм байдлаар нэлээд хэдэн хүүхдээр сайн сонголтын жишээ болон үр дагаврыг хэлүүл.



тохиолддог жам ёсны зүйл гэдгийг тайлбарла; жишээ нь, хэрэв бид хөгжмийн аль нэгэн зэмсгээр тоглож сурахаар сонговол хөгжим сайн тоглож сурна, хэрэв бид галд гараа хүргэвэл түлэгдэнэ. Саваа модыг хүүхдүүдэд өргөж харуулаад, та нар үүнийг авах болгондоо сонголт


Давтах замаар хүүхдийн мэдлэгийг бататга. “Сонголт ба үр дагавар” савааг хадгал. Савааг хичээлийн жилийн турш хуваалцах цагаар ашиглах өөр тохиолдлууд гарах болно.



Ойлголтыг урамшуулан дэмж (*Судрын түүхүүдийг судал*): Зөв сонголт хэрхэн эрх чөлөө, аз жаргал өөд хөтөлж, буруу сонголт хэрхэн боолчлол ба зовлон уруу хөтөлдгийг харуулсан түүхүүдийг сарын эхний хоёр долоо хоногт заа. Аврагч болон Сатаны талаар дурдсан дараах судрын түүхүүдийг та ашиглаж болно (Моше 4:1–4-ийг үз); Нифай, Лемел, Лемүел гурав (1 Нифай 2–4, 7, 18-ыг үз); Шадрах, Мешах, Абеднего нар (Даниел 3); эсвэл Алма, Ноа Хаан (Мозая 17–19-ийг үз). Аль нэг түүхийг заасны дараа хоёр хүүхдийг урьж, “сонголт ба үр дагавар” гэсэн савааны хоёр үзүүрээс бариул. Судрын түүхэн дэх хүмүүсийн хийсэн сонголтыг тайлбарлахыг нэг хүүхдээс, уг сонголтын үр дагаврыг тайлбарлахыг нөгөө хүүхдээс хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (*түүхийг сонссоны дараа*) Есүс Христийн зургийг самбар дээр байрлуул.

Уг зураг уруу хөтөлсөн хөлийн мөр зур. Цаасан дээр савааны зургийг зурж, хөлийн мөрний доод талд байрдуул. Нэг өдрийн турш хүүхдийн хийж болох сонголтуудын тухай товч ярь. Аль нэг сонголтын тухай хэлэхэд уг сонголт сайн сонголт бол суудлаасаа бо-сохыг, муу сонголт бол суухыг хүүхдүүдээс хүс. Жишээ нь, “Жейн жаахан дүүгийнхээ тоглоомыг булааж авахад дүү нь уйлжээ. Жейний ээж дүү нь яагаад уйлж байгааг асуухад Жейн мэдэхгүй гэжээ” Сайн сонголт бүрд савааны зургийг Есүс өөд нэг алхам дөхүүлж тавь. Савааны зураг Аврагчид хүртэл өөр сонголтуудын жишээг хэлж үргэлжлүүл. Сайн сонголтууд биднийг хэрхэн аз жаргалтай болгож, Их Эзэнд ойртуулдаг тухай ярилц.



3 дахь долоо хоног: Мөнх бус байдлын өмнөх амьдралд би Бурханы төлөвлөгөөг дагахаар сонгосон.

Ойлголтыг урамшуулан дэмж (*дуу дуул*): Дараах үзэл баримтлалыг товч ярилцаад доорх дуунуудаас тохирох дууг хүүхдүүдтэй хамт дуул: Би дэлхийд ирэхээсээ өмнө тэнгэрт амьдарч байсан (“I Lived in Heaven [Би тэнгэрт амьдарч байсан]” [CS, 4]). Би дэлхийд ирж, бие махбодтой болохыг сонгосон (“Би Бурханы хүүхэд” [CS, 2–3]; “The Lord Gave Me a Temple


[Их Эзэн надад ариун сүм өгсөн]” [CS, 153]). Би баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авна (“When I Am Baptized [Би баптисм хүртэхдээ]” [CS, 103]; “Ариун Сүнс” [CS, 105]). Би ариун сүм уруу явахаар бэлтгэж чадна (“Би ариун сүм харах дуртай” [CS, 95]; “Гэр бүлүүд үүрд хамт байж чадна” [CS, 188]). Би амилна (“Тэр хүүгээ илгээсэн” [CS, 34–35]).

Дөрөв дэх долоо хоног: Намайг зөвийг сонгож сурах газар болгож Есүс Христ дэлхийг бүтээсэн юм.

Сургаалыг тань (*үзүүлэн хичээлийг үзэж, ярилцсаны дараа*): Олон өнгийн харандаагаар дүүрэн савыг хүүхдүүдэд үзүүл. Дараа нь зөвхөн ганцхан өнгийн будагтай савыг үзүүл. “Хэрэв та нар зураг будахыг хүсвэл эдгээр

будгийн харандаануудтай савнаас алийг нь ашиглахыг хүсэх вэ? Яагаад?” Сонголтын олон хувилбар байна гэдэг нь адислал болохыг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бидэнд хайртайг мөн биднийг зөв сонголт хийгээсэй гэж хүсдэгийг гэрчил.

Ойлголтыг урамшуулан дэмж (*зураг будах*): Бага насны хүүхдүүдийн ангийн гарын авлагын 35-р хуудсан дээрх *Бяцхан үрсээ анхаар* зургийн хуулбарыг хүүхдүүдээр будуулах буюу энэ зурагтай адил төстэй зураг зуруул. Зураг дээрх зүйлсийг хэн, юуны учир бүтээснийг ярилц. Бидэнд зориулан Хүүгийнхээ бүтээсэн энэ дэлхийд анхаарал тавьж байхыг Тэнгэрлэг Эцэг биднээс хүсэн хүлээдгийг хүүхдүүдэд заа. Дэлхий болон түүн дээрх бүтээлүүдэд анхаарал тавихын тулд тэдний сонгож болох арга замуудаасаа хуваалцахыг хүүхдүүдээс хүс. Зурсан зургаа гэртээ аваачиж, аав, ээжээсээ зургаа номонд оруулахыг хүсэхийг хүүхдүүдэд хэл.



Үзүүлэн хичээл

“үл үзэгдэх санааг . . . суралцагчдын сайн мэдэх бодит зүйлтэй холбон, мэдлэг олго”

(Boyd K. Packer, TNGC, 163).



Энэ үйл ажиллагаагаар дамжуулан та өнгийн харандаанууд болон янз бүрийн жимс эсвэл хүүхдүүдийн сайн мэдэх бусад зүйлсээр жишээ татан сонголт бол адислал юм гэсэн үзэл баримтлалыг бий болгож чадна.

Хоёрдугаар сар

Дуу: “Choose the Right” (Зөвийг сонго)
(Hymns, no. 239)


Бид зөвийг сонгосноор адислагддаг

“Хэрэв та нар түүний зарлигуудыг дагавал тэр та нарыг адисалж мөн та нарыг дэгжээх бөлгөө” (Мозая 2:22).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдэх долоо хоног: Ноа зөвийг сонгосныхоо төлөө адислагдсан юм.

Сургаалыг тань (тохируулах тоглоом тогло): Энгийн хөвөгч авдрыг самбар дээр зур. Хэд хэдэн адилхан хоёр амьтны зургийг бэлтгэ. Хүүхэд бүрт нэг зураг өг. Хүүхдүүдийг босч зураг дээрх амьтан яаж дуугардгийг дуурайн авиа гаргахыг мөн өөртэй нь адилхан авиа гаргасан хүнийг сонсохыг хүүхдүүдээс хүс. Тохирох зурагтай хүүхдүүд бие биенээ олж, бүх амьтад хос хосоороо болж дуустал хамтад нь зогсооно. Амьтдаа хосоор нь болгож дууссаны дараа зургаа хөвөгч авдар дээр тавихыг хүүхдүүдээс хүс. Тэгээд хүүхдүүдээс ингэж асуу, “Их Эзэн ямар бошиглогчоос амьтдыг хөвөгч авдарт оруулахыг хүссэн бэ?” Ийм олон амьтныг хөвөгч авдарт цуглуулах нь хэцүү боловч, Ноа Их Эзэний зарлигийг дуулгавартай дагахаар сонгосон юм.



Зургийг интернетэд sharingtime.lds.org хаягаар орж үзэж болно

Ойлголтыг урамшуулан дэмж (судар унш):

Сургаалыг номлож байгаа Ноагийн зургийг хүүхдүүдэд үзүүлж, Мосе 8:20-ийг унш. Хүмүүс яагаад Ноаг сонсоогүй гэж боддогийг нь хүүхдүүдээс асуу. Самбарыг хоёр хувааж нэг тал дээр нь дараах асуултуудыг, нөгөө тал дээр нь судрын эшлэлүүдийг дэс дарааллыг нь харгалзахгүйгээр бич. Их Эзэн ёс бусчуудыг устгахын тулд юу хийсэн бэ? (Эхлэл 6:17). Их Эзэн Ноаг гэр бүлээ аврахын тулд юу хий гэсэн бэ? (Эхлэл 6:18). Ноа зөвийг сонгохын тулд юу хийсэн бэ? (Эхлэл 7:5). Судруудыг уншаад асуулт бүрд аль нь хариулж байгааг олохыг хүүхдүүдээс хүс. Хөвөгч авдар барьж байгаа Ноагийн зургийг хүүхдүүдэд үзүүл. Зөвийг сонгох нь зарим үед хэцүү байдгийг тайлбарла. Асуулт: “Ноа зөвийг сонгосныхоо төлөө хэрхэн адислагдсан бэ?” Зөвийг сонгосноороо хэрхэн адислагдах тухайгаа хуваалцахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.



Хүндэтгэл: Хүүхдүүд хөгжилтэй үйл ажиллагаа болон үйл хөдөлгөөнөөр дамжуулан сурахдаа ч хүндэтгэлтэй байж чадна. “Хүндэтгэл бол . . . чив чимээгүй байх явдал биш” (Бонд К. Пакер, “Reverence Invites Revelation,” Ensign, 1991 оны 11-р сар, 22).

Хоёрдахь долоо хоног: Есүсийн шавь нар зөвийг сонгосноороо адислагдсан юм.

Ойлголтыг урамшуулан дэмж (судрууд уншиж, зураг будан, хүүхэддэйнүүдийг ашигла):

Есүсийн шавь нар зөвийг хэрхэн сонгож байсан тухай дараах шастируудыг хүүхдүүдтэй хамт унш: Лук 10:38–42 (Мариа); Матай 4:18–20 (Петр, Андрей хоёр); Үйлс 9:1–9, 17–20 (Паул). Зөвийг сонгосныхоо төлөө эдгээр хүмүүсийн хүлээн авсан зарим адислалуудын тухай ярилц. Хүүхэд бүрд

Хичээлийн нэг хэсгийг жүжигчилсэн тоглолт болгоход энгийн хүүхэддэйнүүдийг ашиглаж болно. Жүжигчилсэн тоглолт нь гол санааг бататгах болон хүүхдүүдийн анхаарлыг татах үнэ цэнэтэй арга хэрэгсэл мөн (TNGC, 176–77-г үз).



зориулан энгийн дүрс зур (эсвэл “Funstuf,” *Friend*, 2006 оны 1-р сар, 35; мөн “Funstuf,” *Friend*, 2006 оны 2-р сар, 31 дэх судрын баатруудыг ашигла). Хүүхдүүдээр зураг будуулж, хайчлуулан, савх эсвэл савхан хүүхэлдэй хийлгэ. Хүүхэлдэйгээ ашиглан судрын түүхүүдийн нэгийг дахин ярихад хүүхдүүдийг урь. Жишээ нь: “Миний нэр Паул. Би Есүсийг дагасан хүмүүсийг хавчиж байсан. Би Есүсийн тухай үзэгдэл үзсэн. Өөрийг нь хавчихыг зогсоохыг Есүс надаас хүссэн. Би Есүсийг дагахаар сонгож, амьдралынхаа үлдсэн хугацаанд номлогч болсон.”

Гуравдахь долоо хоног: Нифай зөвийг сонгосны учир адислагдсан.


Ойлголтыг урамшуулан дэмж (*жүжигчилсэн тоглолтонд хүүхдүүдийг оролцуул*): Нифай аавыгаа болон Их Эзэнийг дуулгавартай дагасан үеийн тухай хүүхдүүдээр жүжигчилсэн тоглолт хийлгэ. (жишээ нь, 1 Нифай 16:18–24, 30–32; 1 Нифай 17:8, 17–18, 48–53; 1 Нифай 18:9–21-ийг үз). Энгийн хувцас өмсгөл, эд хэрэглэлийг тэднээр ашиглуулж болно (жүжигчилсэн тоглолтын тухай мэдээллийг *TNGC*, 165–66-гаас үзнэ үү). 1 Нифай 17:3 дахь Нифайн хэлсэн үгсийг хамт унш.



Дөрөвдэх долоо хоног: Өнөөдөр Сүмийн гишүүд зөвийг сонгосныхоо төлөө адислагдаж байна.

Ойлголтыг урамшуулан дэмж (*түүхүүдийг хуваали*): Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдийн хэд хэдэн эцэг эх эсвэл өвөө, эмээ нарыг урьж, тэд өөрсдөө болон өвөг дээдэс нь хэрхэн зөвийг сонгож байсан тухайгаа ярихыг тэднээс хүс. Үүнд: Тэд хэрхэн сүмд нэгдэхийг сонгосон тухай түүх байж болно. Ийнхүү түүх бүрийг ярихын өмнө Сүмийн эдгээр гишүүд зөвийг

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (*судрын түүхүүдийн нэгтгэн дүгнэ*) Хүүхэлдэйгээ ашиглан судрын түүхүүдийг гэрийнхэндээ ярьж өгөхөд хүүхдүүдийг урь. Судрын түүхүүд дэх хувь хүмүүс хэрхэн зөвийг сонгосон болон хэрхэн адислагдсан тухай гэрийнхэнтэйгээ хуваалцахад хүүхдүүдийг урамшуулан дэмж. Ирэх долоо хоногт хэрхэн зөвийг сонгохыг нь тэднээс асуу.



Савхан хүүхэлдэйнүүдийг sharingtime.lds.org-c харж болно.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (*нэг дуу дуул*): Нэгдүгээр сард хэрэглэсэн “сонголт ба үр дагавар” савааг үзүүлж, сонголт ба үр дагаврын тухай санаж байгаа зүйлээ хуваалцахад хүүхдүүдийг урь. Бидний хүлээн авсан олон адислал бол бидний хийсэн зөв сонголтуудын үр дагавар мөн гэдгийг тэдэнд хэл. Нифайтай адилхан болж, зөв сонголтууд хийж болох арга замуудын тухай бодоход хүүхдүүдийг урь. “Нифайн зориг” (*CS*, 120–21) дууг хүүхдүүдээр дуулуулж, тэднийг дуулж байх үеэр “сонголт ба үр дагавар” савааг хүүхдүүдэд дамжуулан үзүүл. Хөгжмийг гэнэт зогсоо. Хөгжим зогсоход савааг гартаа барьж байгаа хүүхдийг өөрийнхөө хийж болох нэг зөв сонголтын тухай хуваалцахад урь. Нөгөөх хүүхдийг саваагаа өөр нэг хүүхдэд өгч, зөв сонголт хийснээр ирэх адислалын тухай хуваалцана уу гэж урь. Цаг байвал үргэлжлүүлэн хий.

Үзүүлэн сургалтын үр дүнг дээшлүүлж чадна. Энгийн үзүүлэнгүүдийг хийж ашиглаад хадгал. Энэ нь хүүхдүүд үзүүлэн дээр биш харин хичээлийн захиаст анхаарлаа илүү хандуулах боломжийг олгоно.

Сургаалыг хэлэх нь:

Бид зөвийг сонговол адислагдана хэмээх сургаалаар хүүхдүүд судрын хэд хэдэн үзүүлэнтэй энэ сард танилцаж, тэдгээрийг мэддэг болно. Хичээл бүрийн эхэнд “Бид зөвийг сонговол адислагдана” гэж хүүхдүүдээр хэлүүлж байхыг бод. Хичээл бүрийн эхэнд “Бид зөвийг сонговол адислагдана” гэж хүүхдүүдээр хэлүүлж байхыг хичээ.

сонгосноороо хэрхэн адислагдсан арга замуудыг анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс. Түүх бүрийг ярьсны дараа тэдгээр гишүүд зөвийг сонгосныхоо төлөө хэрхэн адислагдсаныг ярихыг хүүхдүүдээс хүс. Сонссон түүхийнхээ тухай зураг зурж, тэр зургаа Хүүхдийн Хэсэг дэх бусад хүүхдүүд болон гэрийнхэнтэйгээ хуваалцахыг тэднээс хүсч болно.

Амьд бошиглогчид надад ЗӨВИЙГ СОНГОХЫГ заадаг

Дуу: “Үнэний төлөө зогс”
(CS, 159)

“Ай, санагтун, хүү минь, мөн насны залууд мэргэн ухаанд суралц, тийм ээ, насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун” (Алма 37:35).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.



Нэгдэх долоо хоног: Бурхан амьд бошиглогчдоор дамжуулан ярьдаг.

Сургаалыг тань (үзүүлэн үзүүлж, судрыг цээжлүүл): Нэг хүүхдийг самбарын өмнө гарч ирэхийг урь. Түүний удирдамжийг дагахыг бусад хүүхдүүдээс хүс. “Гурван удаа алгаа таш гэж тэдэнд хэл,” “Босч дороо алх гэж тэдэнд хэл” гэхчлэн энгийн заавруудыг уг хүүхдэд шивнэж хэл. Нэлээд хэдэн хүүхэд ээлжээр удирдагч болох хүртэл үргэлжлүүл. Тэд хэдийгээр өөрийг тань заавар өгч байгааг сонсоогүй ч гэсэн хэнийг дагахаа мэдэж байсан

учир заавруудыг дуулгавартай биелүүлж байсныг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг биднээр юу хийлгэхийг хүсч байгааг мэдэхийн тулд бид хэнийг дагах ёстойг асуу. Сүмийн одоогийн Ерөнхийлөгчийн зургийг үзүүл. “Бурхан амьд бошиглогчдоор дамжуулан ярьдаг” гэж хүүхдүүдийг хамтад нь хэлүүл. Амос 3:7-г уншиж, хүүхдүүд ойлгохгүй үг байвал тайлбарла. Уг судрыг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал (TNGC, 171–72-ыг үз).

Хоёрдахь долоо хоног: Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгч бол бошиглогчид.

Сургаалыг таньж мэд: “Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгч бол бошиглогчид” гэж самбар дээр бич. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд биднийг Сүмийн Ерөнхийлөгч болон Тэргүүн Зөвлөл дэх түүний хоёр зөвлөх, Арванхоёр Төлөөлөгчид удирддагийг хүүхдүүдэд хэл. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгч бол бошиглогчид гэдгийг тайлбарла.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (тохируулах тоглоом тогло): Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулгын зургаан гишүүний зургийг сонгон авч тэдний нэрийг тус тусад нь нэг цаасан дээр бич. Цаас болон зурагнуудыг самбар дээр цааш нь харуулан тавь. Нэг хүүхдээр зургийг, өөр нэг хүүхдээр нэртэй цаасыг эргүүлүүлж нааш нь харуул. Хэрэв зураг, нэр хоёр тохироогүй бол тэдгээрийг буцааж тавиад, өөр хоёр хүүхдээр сонгуул. Хэрэв зураг, нэр хоёр тохирвол хамгийн сүүлчийн ерөнхий чуулган дээр удирдагчийн заасан сайн мэдээний зарчмыг тэрхүү хоёр хүүхдэд шивнэж хэл (Ensign эсвэл Лиакхона) болон хамгийн сүүлчийн ерөнхий чуулганы яриаг үз), тэгээд уг зарчмаар амьдрах арга замыг тэднээр жүжигчлэн тоглуул. Тэдний юу хийж байгааг бусад хүүхдүүдээр таалга.

Асуултууд асуу

Асуултууд нь хүүхдүүдийг ярилцлагад оролцоход нь дэмждэг. Хүүхдүүд зааж буй сургаалыг тань ойлгосон эсэхийг тодорхойлоход туслах асуултуудыг асууж, тунгаан бодоход нь тэднийг урамшуулан дэмж (TNGC, 73-ыг үз). Жишээ нь, “Тэнгэрлэг Эцэг Сүмийн гишүүдэд хандан хэрхэн ярьдаг вэ?”, “Бошиглогчийг дагаснаараа та нар хэрхэн адислагдсан бэ?” зэрэг асуултуудыг асууж болно.



Гуравдахь долоо хоног: Бурханы бошиглогчид болон төлөөлөгчид ерөнхий чуулган дээр бидэнд хандан үг хэлдэг.



Заадаг хүүхдүүдийнхээ нас, чадварт тохируулан үйл ажиллагаануудыг өөрчил. Гуравдахь долоо хоногийн үйл ажиллагаануудад захиас бичгээс гадна зураг ашиглаж болно.

Ойлголт болон сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж

(тоглоом тогло): Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийн хэлсэн хамгийн сүүлчийн захиасуудаас хураангуйлан нэг өгүүлбэрийг тусад нь цаасан дээр бич. Захиасуудыг удирдагчдын зурагтай хамт самбар дээр байрлуул. Захиас бүрийг ярилц. Нэг хэсэг хүүхдийг ангиас гарна уу гэж хүс. Самбар дээрээс захиасуудын нэгийг ав. Хүүхдүүдийг ангид нь буцаан оруулж ирээд ямар захиас алга байгааг хамтдаа олохыг хүс. Уг захиастай холбоотой Хүүхдийн Хэсгийн нэг дуу сонгож, хамтдаа дуулахыг хүүхдүүдээс хүс. Энэ захиасыг амьдралд хэрэгжүүлэх арга замуудыг нэрлэхийг хүүхдүүдээс хүс. Бусад захиасуудыг давтан хэлүүл.

Дөрөвдэх долоо хоног: Би бошиглогчийг дагахаар сонговол адислагдана.

Сургаалыг тань Identify the doctrine (дуу дуул): “Follow the Prophet (Бошиглогчийг дага)” (CS, 110–111) дууллын эхний мөрийг дахилтын хамт дуул. Бид яагаад бошиглогчийг дагах ёстойг анхааран сонсоход хүүхдүүдийг урь. “Би бошиглогчийг дагахаар сонговол адислагдана” гэсэн үгсийг хүүхдүүдээр хамтад нь хэлүүл.

Ойлголтыг урамшуулан дэмж (судрын түүхээр жүжигчилсэн тоглолт хийлгэ): Елиа болон Зарефатын бэлэвсэн эмэгтэйн тухай түүхийг хүүхдүүдэд ярьж өгөөд (Хаадын дээд 17:8–16-г үз), хүүхдүүдийг өөртэйгөө хамт жүжигчлэн тоглоход урь. Жишээ нь: “Их Эзэн бошиглогч Елиад Зарефат гэдэг хот руу яв гэж хэлсэн (дороо алхална). Тэр хотод хүрч ирээд мод түүж байгаа эмэгтэйг харсан (газраас мод түүж байгаа дүр үзүүлнэ). Елиа нөгөөх эмэгтэйдээс уух юм (хэн нэгэнд уух юм өгч байгаа дүр үзүүлнэ) бас зүсэм талх өгөхийг гуйна. Хүүдээ талх жигнэж өгөхөд дөнгөж хүрэх жаахан гурил, тос л байна гэж нөгөөх эмэгтэй Елиад хэлнэ (үгүй гэж толгой сэгсэрнэ). Хэрэв өөрт нь эхлээд талх жигнэж өгвөл Бурхан түүнд бүр их гурил, их тос өгөх болно гэж Елиа бэлэвсэн эмэгтэйд хэлэв. Эмэгтэй Елиаг дуулгавартай дагав (талхны гурил зуурч байгаа дүр үзүүлнэ). Тэр эмэгтэй олон хоног талх хийхэд хангалттай гурил, тостой болжээ (идэж байгаа дүр үзүүлнэ). Мосе болон гуулин могой, (Тооллого 21:5–9-ийг үз), Нифай болон гуулин ялтсуудын түүхийн тухай үйл ажиллагааг

давтан үзүүл (1 Нифай 3–4; 5:21–22-ыг үз). Эдгээр түүхүүд дэх хүмүүс бошиглогчийн зөвлөгөөг дагаснаар хэрхэн адислагдсан тухай хуваалцахыг хүүхдүүдээс хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (бошиглогчийн сургаалуудаас ярилц): “Өнөөдөр хэн бидний бошиглогч вэ?” гэж хүүхдүүдээс асуу. Сүмийн одоогийн Ерөнхийлөгчийн зургийг үзүүл. Тэрээр Бурханаас дуудагдсан гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг жижиг бүлгүүдэд хуваан түүнийг хэрхэн дагаж болох тухай ярилцуул. Бүлэг бүрээс цөөн хүүхдээр бодол санааг нь хуваалцуул. Ирэх долоо хоногийн турш бошиглогчийг дагах нэг арга замыг сонгоход хүүхдүүдийг урь. Өөрсдөд нь үүнийг сануулах нэг аргыг бодож олон гэртээ хариад үүнийг гэрийнхэнтэйгээ хуваалц. Ерөнхий чуулганы үеэр бошиглогчийн үгсийг сонсож болно гэдгийг хүүхдүүдэд сануулж, чуулганыг гэрийнхэнтэйгээ үзэх буюу сонсохыг нь урамшуулан дэмж. Бошиглогчийг сонсож, сургаалуудыг нь дагасан туршлагаа хуваалцахыг ерөнхий чуулганы дараагийн долоо хоногт зарим хүүхдээс хүс.



Зөвлөгөө:

conferencegames.lds.org дахь эх сурвалжуудын тухай хүүхдүүд, болон тэдний эцэг эхчүүд мэдэх арга замуудын талаар бод.

Давталт: Хүүхдүүд давталтаар дамжуулан сурдаг. Та хоёрдахь, гуравдахь долоо хоногуудад адил сургаалыг өөр өөр аргаар заах болно. Энэ нь сургаалын тухай тэдний ойлголтыг бататгах нэг боломж байх болно.



Хүүхдүүдийг бүлэг болгож хуваах нь илүү олон хүүхдийг хичээлд оролцуулах боломж юм. Олон хэлбэрээр бүлгүүд болгон хувааж болно. Жишээ нь, та ангийг хамтран ажиллах бүлгүүд болгон хувааж болно эсвэл ахмад хүүхдүүдийг бага насны хүүхдүүдтэй нэг бүлэг болгож болно. Бүлэг бүрд насанд хүрсэн нэг хүн хяналт тавих хэрэгтэй.

Есүс Христ надад зөвийг СОНГОХЫГ заадаг

Дуу: Хүүхдийн дууны номноос
Есүс Христийн тухай дууг сонгож дуул.



Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдийн нас, тоонд тохируулан **үйл ажиллагаануудыг өөрчилж** болно. Жишээ нь, Хэрэв танай хүүхдийн хэсгийн нэгдэх долоо хоногийн үйл ажиллагаагаар олон хүүхэд байвал хайчилж, эвлүүлэх тоглоомоо нэгээс илүү олноор бэлтгэж болно. Бага насны хүүхдүүдэд багш судрыг уншиж өгөөд судрын агуулгын тухай зураг зурахад нь хүүхдүүдэд тусалж болно.

“Учир нь Миний та нарт юу хийснийг та нар бас хийх хэрэгтэй гэж Би ийм жишээ үзүүлсэн юм” (Иохан 13:15).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**

Нэгдэх долоо хоног: Есүс Христ бол миний төгс үлгэр жишээ мөн.

Ойлголтыг урамшуулан дэмж (судрууд уншиж, зураг зур): “Есүс Христ бол миний төгс үлгэр жишээ мөн” гэсэн өгүүлбэрийг том цаасан дээр бич. Цаасыг дөрвөн хэсэг болгон хайчил. Дараах өгүүлбэрүүдийн нэгийг дөрвөн хэсэг болгож хайчилсан цаас бүрийн ар дээр бич:

- Баптисм хүртэх замыг Тэр бидэнд харуулсан (Матай 3:13–17-г үз).
- Бусдыг хайрлах хайрыг Тэр харуулсан (Марк 10:13–16-г үз).
- Тэр Өөрийг нь гомдоосон хүмүүсийг уучилсан юм (Лук 23:34-ийг үз).
- Тэр хэрхэн залбирахыг бидэнд харуулсан (Матай 6:5–13-ыг үз).

“Би Есүс шиг байхыг хичээдэг” (CS, 78–79). Энэ дуу юу зааж байгааг тайлбарлахыг хүүхдүүдээс хүс. Христийн зургийг үзүүлж, Тэр Өөрийн төгс үлгэр жишээгээр дамжуулан бидэнд олон зүйлийг заасныг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдийг дөрвөн бүлэгт хувааж, бүлэг бүрд хуваасан



Сайн мэдээний зарчмуудыг заахдаа эдгээрийг амьдралдаа хэрэгжүүлэх арга замуудыг олоход нь хүүхдүүдэд тусал.

цаасны нэгийг нэг цулгуй цаасны хамт өг. Судрыг хамтдаа уншсаны дараа Христийн үлгэр жишээг хэрхэн дагаж болох тухай зураг зурахыг хүүхдүүдээс хүс. Бүлэг бүрийг өөрийн судар болон зургийг тайлбарлаж, авсан цаасаа самбар дээр байрлуулахыг хүс. Дөрвөн хэсэг болгон хуваасан цаасыг эвлүүлсний дараа “Есүс Христ бол миний төгс үлгэр жишээ мөн” гэсэн өгүүлбэрийг хамтдаа уншин давт.

Хоёрдахь ба гуравдахь долоо хоног: Есүс Христ зөв амьдрах замыг надад заасан.

Сургаалыг тань (дуу дуул): “Choose the Right Way” (CS, 160–61) дууг дуулахдаа хүүхдүүдийн хагасыг бид хэрхэн аз жаргалтай байж болохыг нөгөө хагасыг амьдралын зөв замыг сонгоход бидэнд юу тусалдаг болон энэ замыг юу бидэнд харуулдгийг олж мэдэхийн тулд анхаар гэж хэл. Хүүхдүүд энэ дуунаас юу сурсныг ярилц.

Ойлголтыг урамшуулан дэмж (таах тоглоом тоглож, дараах судруудыг унш): Дараах үгс болон судрын эшлэлийг зурвас цаасан дээр бичиж бэлтгэ: өлсгөлөн (Матай 5:6); гэрэлтэх (Матай 5:16); хайр (Матай 5:44); залбирах



Зурвасыг sharingtime.lds.org -аас авч болно

(Матай 6:6). Уулан дээрх Номлолын зургийг үзүүл. Есүс дагалдагчиддаа заахын тулд уулан дээр гарсныг мөн Түүний заасан зүйлсийг одоо Уулан дээрх Номлол гэж нэрлэдгийг тайлбарла. Зурвас цааснуудын нэгийг хүүхдүүдийн хагаст үзүүлж, энэ үгийг үйлдлээр харуулахыг тэднээс хүс. Бусад хүүхдүүдээр үгийг таалга. Холбогдох судрыг хамтдаа уншиж, Христ бидэнд юу заасныг болон Түүний үлгэр жишээг бид хэрхэн дагаж болохыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Бусад үгс болон судруудыг давт.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (сурч мэдсэн зүйлсээ ярилц): Есүсийн дараах сургаалуудыг дөрвөн цаасан дээр бич: (1) Зөв шударга байдлын төлөө өлсөж, цанга, (2) та нарын гэрэл гэрэлтэг,

(3) дайснаа хайрла, (4) Тэнгэрлэг Эцэгт хандан залбир. (Эдгээр сургаалуудыг дүрсэлсэн зургуудыг бага насны хүүхдүүдэд зориулан ашиглахыг бод.) Сургаал бичсэн цаасуудыг ангийн өөр өөр хэсэгт тавь. Эдгээр сургаалуудыг амьдралд хэрхэн хэрэгжүүлэхийг ойлгоход нь туслах жишээнүүдийг бэлтгэ (TNGC, 161–62-ыг үз) Жишээ нь “Сургууль дээр чинь хэн нэгэн нь чамайг шоолж, нэр хоч өгдөг ажээ. Чи яах вэ?” Дээр дүрсэлсэн таавар тоглоом дахь судруудыг нэгтгэн дүгнэж, ангид дэлгэн тавьсан цаасан дээрх өгүүлбэрүүд нь тус бүрдээ судруудтай холбогдож байгааг хэл. Нэг жишээг хүүхдүүдэд уншиж өгөөд, тэднийг босч, зөвийг сонгоход нь туслах сургаалтай цаас уруу харж зогсохыг хүс. Ямар сонголт хийхийг нь хоёр гурван хүүхдээс асуу.



Хүүхдүүдээс судруудаас чангаар уншихыг хүс. Хүүхэд бүрийн чадварыг харгалзан, хичээлд идэвхтэй оролцоход нь тусал.

Дөрөвдэх долоо хоног: Би Есүс Христтэй адилхан байхыг хичээсэн үедээ Аврагчийн хайрыг мэдэрдэг.

Ойлголтыг урамшуулан дэмж (дуу дуулж, сонголтууд хий): “I Feel My Savior’s Love” (CS, 74–75) дууг дуул. Хүүхэд Христийн сургаалуудын аль нэгийг хэрхэн дагаж болох тухай харуулсан хэдэн жишээг самбар дээр бич. Мөн энэ сургаалыг агуулсан судрын эшлэлийг хамт зааж өг. Жишээнүүдээс доор харуулав.

Сара будгийн харандаануудаараа битгий юм зураараай гэж жаахан эмэгтэй дүүдээ хэлжээ. Гэвч дүү нь харандаануудыг хэрэглэсэн байжээ. Сара Есүс шиг байхын тулд:

- Дүүдээ уурлаж болох байв.
- Будгийн харандаануудаа нууж болно.
- Дүүгээ уучилна.

Матай 18:21–22.

Жон найз нартайгаа хөл бөмбөг тоглож байхдаа өөр нэг хөвгүүн тэднийг тоглохыг харан дэргэд нь зогсож байхыг харжээ. Жон Есүс шиг байхын тулд:

- Тэр хөвгүүн ганцаараа байгааг нь хараад түүгээр тоглоом наргиа хийнэ.

- Хөвгүүнийг тоохгүй, найз нартайгаа үргэлжлүүлэн тоглоно.
- Хөвгүүнийг өөрсөдтэйгөө хамт хөл бөмбөг тоглооч гэж урина.

Иохан 13:34.

Жишээнүүдээс нэгийг нь уншихыг нэг хүүхдээс хүс. Тэгээд хариунуудыг нэг нэгээр нь уншихыг түүнээс хүс. Есүсийн үлгэр жишээг дагасан хариултыг сонссон үедээ босохыг бусад хүүхдүүдээс хүс. Судрыг чанга уншихыг хэдэн хүүхдээс хүсээд Есүсийн заасан зүйлийг ярилц. Дээрх жишээнүүдэд Есүсийн үлгэр жишээг дагах нь Аврагчийн хайрыг мэдрэхэд бидэнд хэрхэн туслах тухай ярилц. Жишээ бүрийг давт.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж Энэ долоо хоногт Есүсийн тэднээр хийлгэхийг хүсдэг зүйлийг хийхэд хүүхдүүдийг урь. Дараагийн долоо хоногт тэдний заримаас нь юу хийсэн болон Аврагчийн хайрыг хэрхэн мэдрэснийг нь хуваалцуулах болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

Хөгжмийн удирдагчид зориулсан тусламж

Шинэ дуу дуулж сурахад нь хүүхдүүдэд туслахын тулд дараах зүйлсийг анхаар:

- Аль нэг онцгой үгийг дуулах үед дохио өгөх буюу энэ үг дуунд хэчнээн удаа давтагдаж байгааг хуруу даран тоолохыг хүүхдүүдээс хүс. “Тэр Хүүгээ илгээсэн” (CS, 34–35) дууллыг дуулахад “Түүний Хүү” гэсэн үг хэчнээн удаа гарч байгааг хуруу даран тоолохыг тэднээс хүс.

- Дууны өгүүлбэр бүрийг төлөөлөх зураг буюу үгийг сонгож, тэдгээрийг цаасан дээр тавь. Жишээ нь, “Тэр Хүүгээ илгээсэн” (CS, 34–35) дууг дуулахад “Тэнгэрлэг эцэг дэлхийд хайр энэрлээ яаж харуулав?” гэсэн өгүүлбэрийг зүрхний зураг болон хайр энэрэл гэсэн үгээр дүрслэн харуул. “Тэр Хүүгээ ариун амар амгалангийн хамт илгээсэн” гэсэн бадагт зориулж Есүсийн төрөлтийн зургийг амар амгалан гэсэн үгийн хамт үзүүл. Дуу дуулж байх үед нь хүүхдүүдээр зургийг өргөн харуулах замаар тэднийг оролцуулж болно.



Би баптисм хүртэж, Сүмийн гишүүнээр батлагдсанаараа ЗӨВИЙГ СОНГОСОН

Дуу: “Намайг баптисм хүртэхэд” (ХДН, 103)

“Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно” (Үйлс 2:38).

Энд дурдсан санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Зөвлөгөө: Нэгдэх

долоо хоногийн үйл ажиллагаагаар та цунх дүүрэн чулуу авчрахыг нэг хүүхдээс хүсч, наманчлал нь цунхнээсээ тэдгээр чулуунуудыг авч хаяхтай хэрхэн адилхан болохыг харуул.

Нэгдэх долоо хоног: Би наманчлах юм бол уучлагдаж чадна.

Ойлголтыг урамшуулан дэмж (үзүүлэнг хичээл заа): Хүүхэд бүрд нэг хайрга (жижиг чулуу) өг. Хайргыг гутал дотроо хийгээд босч, явахыг тэднээс хүс. Гутал дотроо хайрга хийгээд явах нь ямар байгааг хүүхдүүдээс асуу. Хайрга нь нүгэлтэй хэрхэн адилхан болохыг асуу. (Нүгэл нь сэтгэл санаанд маш их дарамттай, хүнийг аз жаргалгүй болгодог.) Хайргыг гутал дотроос нь авахуулсны дараа



наманчилж, Тэнгэрлэг Эцэгийнхээ уучлалыг хүлээн авах нь гутал дотроосоо хайргыг авч хаяхтай хэрхэн адилхан болохыг хүүхдүүдээс асуу. Бид Есүс Христийн улмаас наманчилж, нүглээсээ уучлагдаж чадна гэдгийг тайлбарла. Наманчлал бол бидэнд аз жаргалыг авчирдаг, Тэнгэрлэг Эцэгийн гайхамшигтай адислал юм гэдгийг гэрчил.

Хоёрдахь долоо хоног: Би баптисм хүртэж, гишүүнээр батлагдсанаар Есүсийн үлгэр жишээг дагадаг болсон.

Ойлголтыг урамшуулан дэмж. (Санах тоглоом тоглож, судруудыг унш): Есүст баптисм хүртээж байгаа Иохан Баптистын зураг болон баптисм хүртэж байгаа нэг хүүхдийн зургийг үзүүл. Хүүхдүүдэд энэ хоёр зургийг 20 секунд харуул. Тэгээд зургуудыг юмаар бүтээгээд, энэ хоёр зурагт яг адилхан хэчнээн зүйл байсныг хэлэхийг хүүхдүүдээс хүс. Тэдний хариултыг самбар дээр жагсаан бичиж болно.

Ямар хүн хүнд баптисм хүртээж болохыг мөн баптисмыг хэрхэн гүйцэтгэх ёстойг мэдэхийн тулд Сургаал ба Гэрээ 20: 72–74-ийг уншихыг хүүхдүүдээс хүс. Ойлгосон зүйлээ хуваалцахад хүүхдүүдийг урь. Баптисм гүйцэтгэж байгаа хүн санваарын эрх мэдэлтэй байх ёстой бөгөөд баптисм хүртэж байгаа хүн усанд бүрэн дүрэгдэх буюу усан дор бүрэн орсон байх ёстой гэдгийг онцгойлон тэмдэглэж хэл. Хоёр зургийг дахин үзүүл. Есүс болон хүүхэд хоёрт хоёуланд нь санваарын эрх мэдэлтэй хүн усанд умбуулалтаар баптисм хүртээж байгааг онцлон тэмдэглэж хэл.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж

 (зураг будаж, дуу дуул):

Бага насны хүүхдийн гарын авлагын 111-р хуудсан дахь *Бяцхан үрсээ анхаар* зургийн хуулбарыг хувилж, будуулахаар хүүхэд бүрт өг. “Баптисм” (ХДН, 100–101) дууг дуулуулж, Есүсийн адилаар баптисм хүртэхэд нь хүүхдүүдийг урамшуулан дэмж. Саяхан баптисм хүртсэн нэг хүүхдээр баптисмынх нь тухай бусад хүүхдүүддээ ярьж өгөхийг хүс.



Бага насны хүүхдийн гарын авлага интернетэд sharingtime.lds.org-t байгаа.

Гурав дахь долоо хоног: Ариун Сүнс надад тусалж чадна.

Сургаалыг тань (үзүүлэнг хичээл заа): Нэг хүүхдийг самбарын дэргэд зогсоо. Тэр хүүхдийн нүдийг боож, ямар нэг тусалцаагүйгээр өөрийнхөө сандлыг олуулж суулга. Үйл ажиллагааг давтан хий, гэхдээ энэ удаа нүдийг нь боосон хүүхдийг удирдаж, гараараа тэмтрэн замыг нь удирдахыг өөр нэг хүүхдээс хүс. Нүдийг нь боосон хүүхэд хоёр дахь удаа яагаад сандлаа амархан олсныг хүүхдүүдтэй ярилц. Ариун Сүнс бидний амьдралд удирдамж чиглэл өгч, бидэнд тусалж чадна гэдгийг тайлбарла. “Ариун Сүнс надад тусалж чадна” гэж хэлэхийг хүүхдүүдээс хүс.



Хүүхдүүдэд үйл явдлыг дүрслэхдээ үзүүлэн ашиглах нь тэдний анхаарлыг төвлөрүүлж, сурч мэдэх үйл явцыг дэмждэг.


Дөрөвдэх долоо хоног: Би ариун ёслолоос хүртсэнээр баптисмын гэрээнүүдээ шинэчилдэг.

Ойлголтыг урамшуулан дэмж (гэрээнүүдийн тухай ярилцаж, судруудыг унш): Гэрээ гэдэг бол Тэнгэрлэг Эцэг болон бидний хоорондох хоёр талын, ариун амлалт юм. Бид тодорхой зүйлсийг хийхээр амлалт өгдөг бөгөөд биднийг амлалтаа биелүүлсэн үед Тэнгэрлэг Эцэг биднийг адислахаар амладаг. Бид баптисм хүртсэнээр Тэнгэрлэг Эцэгтэй гэрээ хийж байгаа юм гэдгийг хүүхдүүдэд сануул. Мөн бид ариун ёслолоос хүртсэнээр тэрхүү

Ойлголтыг урамшуулан дэмж. (дуу дуулж, тохируулах тоглоом тогло): Туслах гэдэг үгийг самбар дээр бич. “Ариун Сүнс” (ХДН) дууг дуулуулж, уг дуунд Ариун Сүнс бидэнд тусалдаг талаар хэчнээн зүйлийг нэрлэж байгааг тоолохыг хүүхдүүдээс хүс.

Хүүхдийн Хэсгийн хичээлийн өмнө урд талдаа ЗС бамбайны зурагтай 10 ширхэг цаасыг бэлтгэ. Цаас бүрийн ар дээр Ариун Сүнс бидэнд хэрхэн тусалдгийг дүрсэлсэн дараах таван өгүүлбэрийн нэгийг нь бич: *Ариун Сүнс биднийг тайтгаруулдаг, Ариун Сүнс Есү Христийн тухай гэрчилдэг, Ариун Сүнс бидэнд заадаг, Ариун Сүнс бидэнд юу хийх ёстой, юу хийх ёсгүйг хэлж өгдөг мөн Ариун Сүнс бидэнд сайныг үйлдэхэд тусалдаг* (өгүүлбэр бүрийг хоёр өөр цаасан дээр бичих хэрэгтэй). Цаасаа ЗС бамбайтай хамт дэс дарааллыг нь харгалзахгүйгээр хүүхдүүд уруу харуулан самбар дээр байрлуул. Цааснуудын нэгийг эргүүлэх нэг хүүхдийг урь. Ар тал дээрх үгсийг хамтдаа хэл. Дараагийн цаасыг эргүүлэх өөр нэг хүүхдийг сонгохдоо үгсийг тохируулахыг хичээ. Цаасны ар тал дээрх үгийг хамтдаа хэл. Хэрэв цааснууд тохирвол, самбар дээрээс ав. Хэрэв тохирохгүй бол буцааж байранд нь тавь. Бүх цаас тохиртол үргэлжлүүлэн хий.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (судруудыг ярилц): Хүүхдүүдийг бүлэг болгон хуваа. Дараах судрын эшлэлүүдийн аль нэгийг бүлэг бүрд өг: Иохан 14:26; Иохан 15:26; 2 Нифай 32:5; С ба Г 11:12. Судраа уншиж, утгыг нь ярилцахыг бүлэг бүрээс хүс. Хүүхдүүд болон тэдний багш нараас Ариун Сүнсний нөлөөг амьдралдаа хэрхэн мэдэрсэн жишээнээсээ хуваалцахыг урь.



ЗС таних тэмдэг
sharingtime.lds.org-т байгаа

Бэлтгэл: Хичээлд бэлтгэх үедээ Сүнсний удирдамжийг эрэлхийлж, хүүхдүүдийнхээ нас, чадвар, нөхцөл байдалд тохируулан санаануудыг өөрчилж хэрэглэ. Жишээ нь, зарим хичээлийн санаануудыг заах үед хэдхэн минут зориулж болно. Та хичээлүүдийг өөрийнхөө санаагаар баяжуулан зааж болно.



Бүх хүүхдийг оролцуул: Бага насны хүүхдүүдийг ахмад хүүхдүүдтэй хос болгох замаар тэднийг хичээлд оролцуулж болно. Жишээ нь, дөрөвдэх долоо хоногийн үйл ажиллагаанд бага насны хүүхдүүд зурвас цааснуудыг өргөн барихад ахмад хүүхдүүд тэднийг зөв дарааллаар болгоход нь тусалж болно.

Зурвасуудыг
sharingtime.lds.org-аас авч болно.

Би сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар зөвийг сонгодог.

Дуу: “Нифайн зориг”
(ХДН)

“Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” (1 Нифай 3:7).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдэх долоо хоног: Би зөвийг хийх хүч чадлын төлөө Тэнгэрлэг Эцэгт хандан залбирдаг.

Сүнсийг урь: Таныг Ариун Сүнстэйгээр заахад, зааж буй сайн мэдээний зарчмууд тань үнэн болохыг Ариун Сүнс гэрчлэх болно (TNGC, 45–46-г үз).

Ойлголтыг урамшуулан дэмж. (залбирлын тухай ярилц): Хүүхдүүдэд утас юм уу холбооны өөр нэг хэрэгслийг үзүүл. Үүнийг хэрхэн ашигладгийг ярилц. Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ хэрхэн харилцаж болдгийг хүүхдүүдээс асуу. Бид утсаар хэн нэгэнтэй ярихын тулд дугаар уруу нь залгадагтай адилхан Тэнгэрлэг Эцэгтэйгээ залбирлаар дамжуулан харилцаж болно, бид зөвийг хийх хүч чадлыг Түүнээс гуйж болно гэдгийг тайлбарла. Хичээл бүр дээр залбирлын аль нэг төрлийн тухай зургийг үзүүл (жишээ нь, хувийн залбирал, гэр бүлийн залбирал, хоол адислах залбирал, ангиараа хийх залбирал). Анги бүрийг өөрсдийнхөө зургийг бусад хүүхдүүдэд үзүүлж, ямар төрлийн залбирлыг энд харуулсныг болон энэ залбирлыг хэзээ, хаана, мөн яагаад хийдгийг ярихыг хүүхдүүдээс хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (тоглоом тогло): Хоёр хоосон хөнгөн цагаан лаазны дээд, доод талд нь жижиг нүх гаргаж, лаазуудыг утсаар холбо. Утсыг чанга татаад, хүүхдүүд зөв зүйлийг хийхийн тулд Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч болох ямар нэг зүйлийг тэднээр ээлжлэн нэг лааз уруу аяархан хэлүүл (жишээ нь, үнэнийг хэлдэг байх, хүндэтгэлтэй байх, эелдэг найрсаг байх гэхчлэн). Өөр нэг хүүхдээр нөгөө лаазыг чагнуул. Зөв зүйлийг хийх хүч чадлыг Тэнгэрлэг Эцэг хэзээ өөрт чинь өгсөн тухай туршлагаасаа хуваалц (эсвэл энэ тухайгаа хуваалцахыг нэг хүүхдээс хүс). Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсож, хариулан, зөв зүйлийг хийх хүч чадлыг бидэнд өгөх болно гэдгийг гэрчил.



Хоёрдахь долоо хоног: Намайг аравны нэгээ төлөхөд Тэнгэрлэг Эцэг адислах болно.

Сургаалыг таниулж, ойлголтыг урамшуулан дэмж (үзүүлэн хэрэглэ): Аравны нэг гэдэг бол чи бүх мөнгөнийхөө арав хуваасны нэгийг Сүмээр дамжуулан Их Эзэнд өгч байгаа хэрэг юм гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд 10 ширхэг зоос үзүүл. Энэ зоосноос хэдийг нь

аравны нэгийг төлөхөд ашиглах ёстойг тэднээс асуу. Аравны нэгийн дугтуй, өргөлийн хуудсыг үзүүлж, бид өргөлийн хуудсыг бөглөж аравны нэгээ дугтуйд хийж, бишоп буюу түүний зөвлөхүүдийн нэгэнд өгснөөр аравны нэгээ төлдгийг тайлбарла.




Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (тоглоом тоглож, гэрчлэлүүдийг сонс): ариун сүм, цуглааны байрууд, дууллын ном Хүүхдийн дууны ном, Хүүхдийн Хэсгийн гарын авлага, судрууд зэрэг аравны нэгээ төлөхөөс ирдэг адислалуудыг төлөөлдөг зүйлсийн зургийг эсвэл тэдгээрийг биет байдлаар нь үзүүл. Сүм эдгээр зүйлсийг аравны нэгийн сангаар бий болгосныг хүүхдүүдэд хэл. Зургууд болон биет зүйлсийг юмаар бүтээ. Нэг буюу хоёр юмыг ав. Бүтээлгийг аваад юу байхгүй байгааг таахыг хүүхдүүдээс асуу. Хэд хэдэн удаа давт. Нүдээр харах боломжгүй өөр адислалууд аравны нэгийг төлснөөс ирдгийг тайлбарла (3 Нифай 24:10-ыг үз). Аравны нэгийг төлснөөр хүлээн авсан адислалуудынх нь тухай нэг юм уу хоёр насанд хүрсэн хүнээр яриул.



Үзүүлэн: Хэрэв та зураг болон бусад үзүүлэн ашиглавал хүүхдүүд илүү сайн сурч, заасан зүйлийг тань удаан хугацаанд санах болно (TNGC, 176, 182–83-ыг үз).

Гуравдахь долоо хоног: Би эрүүл хүнсийг хэрэглэж, хортой зүйлсээс зайлсхийснээр Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай сахьдаг.

Ойлголтыг урамшуулан дэмж. (судруудыг уншиж, тоглоом тогло): 1 Коринт 3:16–17-г хамтдаа унш. Энэ судар тэдэнд хэрхэн хамаатайг хуваалцуулахаар хүүхдүүдийг урь. Тэнгэрлэг Эцэг биднийг өөрсдийнхөө биед анхаарал тавьж байхыг хүсдэг гэдгийг тайлбарла. Янз бүрийн хүнсний зүйл, ундаа, хүний биед сайн болон муу бусад зүйлсийн (жимс, хүнсний ногоо, талх, архи, тамхи зэрэг) зурагнуудыг саванд хий. Бага насны хүүхдийн гарын авлагын 43-р хуудсыг хувилж, эвлүүлэх хэсгүүд болгон хайчил. Саван дотроос зургуудыг



хүүхдүүдээр ээлжлэн гаргуул. Хэрэв зураг дээрх зүйл бидний биед сайн бол эвлүүлэх хэсгийг нэг хүүхдээр самбар дээр тавиул. Хэрэв тухайн зүйл бидний биед муу бол эвлүүлэх хэсгийг авч тавь. Эвлүүлэг дуустал тоглоомыг үргэлжлүүл (саван дотор хүний биед муу зүйлсээс сайн зүйлс илүү олон байх хэрэгтэй). Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагаснаар хүлээн авсан адислалуудыг нь нэг насанд хүрэгчээр эсвэл хүүхдээр хуваалцуул (С ба Г 89:18–21-ийг үз).


Бага насны хүүхдийн гарын авлага sharingtime.lds.org-т байгаа.

Дөрөвдэх долоо хоног: Би даруу хувцасласнаар Бурханы бэлэг болох биеэ хүндэтгэдэг.

Сургаалыг тань (зураг үзэж, судар унш): Дараах үгийг самбар дээр бич. “Миний [бие] ____ бол ____ [ариун сүм].” Ариун сүмийн зураг үзүүл. Асуулт: “Ариун сүм яагаад маш чухал вэ?” Хүүхдүүдээр 1 Коринт 6:19-ийг уншуул. Энэ судрыг тантай хамт чанга унших үед уг судар тэдний биеийн тухай юу өгүүлж байгааг олж мэдэхийг тэднээс хүс. Самбар дээрх өгүүлбэрийг ямар үгсээр гүйцээж бичихийг хүүхдүүдээс хүс (бие, ариун сүм). Хүүхдүүдийг босч, өгүүлбэрийг хамтдаа хэлэхийг урь.

Ойлголтыг болон Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (дуу дуулж, ярилц): Бидний бие бол Ариун Сүнс дотор нь оршдог ариун сүм юм гэдгийг хүүхдүүдэд хэл. “Их Эзэн надад ариун сүм өгсөн”

(ХДН,) дууны нэгдүгээр бадгийг дуул. Тэнгэрлэг Эцэг биднийг хэрхэн хувцаслахыг хүсдэг мөн яагаад ингэж хүсдэг талаар бодлоо хуваалцахыг хүүхдүүдээс хүс. Бурханы бошиглогчид Түүний хүүхдүүдэд даруухан хувцаслахыг үргэлж зөвлөсөөр ирснийг тайлбарла. Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлын “Хувцаслалт ба гадаад төрх” хэсгийг уншаад энд биеийн аль хэсгүүдийг далдлах тухай өгүүлж байгааг сонсохыг хүүхдүүдээс хүс. Даруухан хувцаслах нэг арга замын тухай бодохыг хүүхдүүдээс хүс. Ямар нэг зөөлөн юмыг нэг хүүхдэд шидэж өгөөд энэ зүйлийн тухай санаа бодлоо хуваалцахыг тэр хүүхдээс хүс. Тэр юмаа өөр нэг хүүхдэд шидэж өгөхийг уг хүүхдээс хүс. Тэр зүйлийг барьж авсан хүүхэд санаа бодлоо хуваалцана. Энэ мэтээр тоглоомыг цааш үргэлжлүүл.



Би сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар зөвийг сонгодог.

Дуу: “Мэргэн хүн, мунхаг хүн хоёр”
(ХДН 281) эсвэл **Хүүхдийн дууны ном-ноос өөр дууг сонгон дуул.**



Зурвасуудыг sharingtime.lds.org-аас авч болно.

Зөвлөгөө: Мацгийн тухай заахдаа бага насны хүүхдүүд мацаг барих хэрэггүй гэдгийг сануул.

“Иймийн тул, Их Эзэний зарлигийг дагахад итгэлийг хичээе” (1 Нифай 3:16).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаагаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**

Нэгдэх долоо хоног: Мацаг барьж, залбирснаар миний гэрчлэл хүчирхэг болно.

Сургаалыг тань (үзүүлэнг хичээл заа):

Мацаг барилт, Залбирал гэж бичсэн хоёр зурвас цаасыг бэлтгэ. Хоёр хүүхдийг хоорондоо ойрхон зогсохыг хүсээд тус бүрд нь нэг зурвас цаас өг. Өөр нэг хүүхдийг тэдний хоорондуур явуул. Зэрэгцэж зогссон эхний хоёр хүүхдийг гараасаа чанга барилцахыг хүсээд нөгөө хүүхдийг тэдний хоорондуур дахин гарахыг оролд гэж хэл. Хоёр хүүхэд гар гараасаа барьсан үед хэчнээн хүчтэй байгааг онцлон тэмдэглэж хэл. Бид мацаг барилт, залбирлыг хамт хэрэглэсэн үед тэдгээр нь илүү хүчтэй болдгийг тайлбарла. “Мацаг барьж, залбирснаар миний гэрчлэл хүчирхэг болно” гэж самбар дээр бичээд хүүхдүүдээр давтан хэлүүл.

Ойлголтыг урамшуулан дэмж (судруудыг сонсож, үзүүлэнг хичээл заа): Алма 17:2–3-ыг уншихдаа сайн мэдээнд хүчирхэг болохын тулд Мозаягийн хөвгүүдийн хийсэн зүйлийг анхааран сонсохыг хүүхдүүдээс хүс. Мозаягийн хөвгүүдэд хүчирхэг болоход нь тусалсан зүйлийг сонсох болгонд булчингаа чангалахыг хүүхдүүдээс хүс.

“Мацаг гэж юу вэ?”, “Бид яагаад мацаг барих ёстой вэ?”, “Хэзээ мацаг барих ёстой вэ?”, “Бид

мацаг барихдаа яагаад залбирах ёстой вэ” гэх мэт нэлээд хэдэн асуулт асууж, мацгийн тухай яриа өрнүүл. (Жозеф Б.Вертлин, “The Law of the Fast,” *Ensign*, 2001 оны 5-р сар, 73–75-ыг үз). Ярилцлага дээр санаа бодлоо нэмсэн хүүхэд бүрийг утасны нэг үзүүрээс бариул. Утасны нөгөө үзүүрийг та өөрөө барь. Ярилцлагын төгсгөлд утасны үзүүрээс барьсан хүүхдүүдийг өрөөний голд ирж, бүх утсыг нийлүүлж мушгиад бат бөх уяа болгохыг хүүхдүүдээс хүс. Бидний нэмсэн утас болгон уяаг илүү бат бөх болгосныг тайлбарла. Ийм байдлаар бид мацаг барьж, залбирах бүрдээ гэрчлэлээ улам бат бөх болгосныг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.



Үзүүлэн нь хийсвэр ойлголтыг ойлгоход хүүхдүүдэд тусалдаг.

Хоёрдахь долоо хоног: Эелдэг найрсаг байна гэдэг нь бусад хүмүүст сайн зүйлийг хийж, хэлж байх явдал мөн.

Сургаалыг тань (судраас эш тат): “Нэг нэгнээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд” (Ефес 4:32) гэж самбар дээр бич. Хүүхэд бүрд 1-6-гийн тоог хуваарилж өг. 1-ийн тоо авсан бүх хүүхэд босч “Нэг” гэж хэлээд түргэн сууна. Тэгэхэд 2-ын тоо авсан бүх хүүхэд босч “нэгнээ” гэж хэлээд түргэн сууна. Өгүүлбэрийн үлдсэн хэсэг дээр ийм байдлаар ажилла. Хэд хэдэн удаа давт. Тэгээд бүх хүүхдүүдээр өгүүлбэрийг давтан хэлүүл.


Ойлголтыг урамшуулан дэмж (түүх сонсож, дуу дуул): “Standing Up for Caleb” мэтийн эелдэг зангийн тухай ямар нэг түүхийг хүүхдүүдэд ярьж өг (*Найз*, 2009 оны 3-р сар, 4–5). Уг түүхийн найрсаг зангийн тухай сонсох үедээ хоёр эрхий хуруугаа өргөж харуулахыг харин найрсаг бус үйлдлийн тухай сонсох үедээ хоёр эрхий хуруугаа доош харуулахыг тэднээс хүс. “Би элэгсэг нэгэн баймаар байна” (ХДН,) дууг дуул. Бид найрсаг хандвал зохих хүмүүсийн тухай дуулсан үедээ босохыг хүүхдүүдээс хүс. Дууг дахин дуулж, “Би элэгсэг нэгэн баймаар байна” гэж дуулах үед хүүхдүүдээр хоёр эрхий хурууг нь өргүүлж харуул.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (найрсаг байх арга замуудыг хуваали): Хүүхдүүдтэй өдөр тутам ойр байдаг нэлээд хэдэн хүнийг (аав, ээж, ах, эгч, дүү, өвөө, эмээ, найз, багш гэх мэт) зурвас цаасан дээр бичих буюу зургаар эсвэл энгийн хэрэглэдэг зүйлсээр нь (жишээ нь аавыг зангиагаар, өвөөг таягаар гэхчлэн) тодорхойл. Эдгээр юмсыг хэдэн хүүхдэд өгөөд тэднийг ангийн өмнө гарч ирэхийг хүс. Хүүхэд бүрээр тэдэнд байгаа зүйлсийнх нь төлөөлж байгаа хүмүүсийн талаар ямар нэг сайхан зүйлийг хэлүүлэх буюу хийлгэ. Дараа нь зурвас цаас, зураг буюу бусад сануулах зүйлсийг хүүхдүүдэд дамжуул. Цаг байвал үргэлжлүүлэн хий.



Гуравдахь долоо хоног: Хүндэтгэл бол Бурханыг гүнээ хүндэлж, хайрлах явдал мөн.

Сургаалыг тань (дуу дуул): Цаасаар зүрх хайчилж, утсаар хооронд нь хэлхэн хэдэн ширхэг хүзүүний зүүлтийг бэлтгэ. “Хүндэтгэл бол хайр” (ХДН) дууны гол чухал үгсийг эсвэл өгүүлбэрийг цаасан зүрх бүр дээр бич (жишээ нь, чимээгүй суух, бодох, мэдрэх гэхчлэн). Хүзүүний зүүлтийг нэлээд хэдэн хүүхдэд зүүлгэ. “Хүндэтгэл бол хайр” дууг дуулахдаа, тэдний зүүсэн цаасан зүрхэн дээрх үг буюу өгүүлбэрийг дуулахад нь хүүхдүүдийг ангийн өмнө хүндэтгэлтэйгээр гарч ирэхийг хүс. Хүзүүний зүүлттэй хүүхдүүдийг дараалан зогсож, энэ дууг дахин дуулахыг урь.




Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (хүндэтгэлийн тухай ярилц): Зурвас цааснуудыг эсвэл нүд, гар, хөл, чих, амны зураг мөн оюун ухааныг дүрсэлсэн зургийг бэлтгэ. Ангийг бүлгүүдэд хувааж, бүлэг бүрээр нэг юм уу хоёр зурвас цаас эсвэл зургийг сонгуул. Биеийнхээ аль нэг хэсэгт хүндэтгэлтэй хандсанаар Бурханд хүндэтгэл, хайраа харуулах хэдэн арга замыг бүлэг бүрээр (үгээр буюу үйлдлээр) хуваалцуул.

Зүрхнүүдийг sharingtime.lds.org -аас авах боломжтой.

Үзүүлэнд хүүхдүүдийг оролцуулах нь тэднийг хичээлд идэвхтэй оролцуулж, бусад хүүхдүүдийн сонирхлыг татахад тусална.



Судрууд: Хүүхдүүдийг өөрсдийнх нь судраас уншуулснаар энэ нь тэдэнд судруудын чухлыг ойлгуулж, Сүнсний урьдаг. Боломжтой бол хүүхдүүдийг судар дээрээ тэмдэглэгээ хийж, дараа нь хамтдаа уншихыг хүс.



Дүрснүүдийг sharingtime.lds.org-аас авах боломжтой.

Дөрөвдэх долоо хоног: Шударга зан гэдэг бол үр дагаврыг нь харгалзахгүйгээр үнэнийг хэлэх явдал мөн.

Ойлголтыг урамшуулан дэмж (үр дагавруудын тухай ярилц): Нэлээд хэдэн жишээг бэлтгэ (TNGC, 161–62-ыг үз). Эдгээр жишээнүүдэд хүүхдүүд шударга эсвэл шударга биш үйлдлийг олж мэдэх болно. Жишээ нь, “Чи дүүгээ цохиод авч. Ээж чинь түүнийг яагаад үйлж байгаа юм бол гэж асуужээ.” Асуулт, “Шударга байснаар ямар үр дагавар гарч болох вэ?” Дараа нь асуу, “Шударга биш байснаар ямар үр дагавар гарч болох вэ?” Шударга зангаас ирэх үр дагаврыг тэр даруйд олж харах нь хэцүү ч урт удаан хугацааны үр дагавар нь амар амгалан, аз жаргал өөд хөтөлдгийг ойлгоход нь хүүхдүүдэд туслах.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (шүлэг зохио): Анги бүрийг (багш нарынхаа тусалцаатайгаар) шударга зангийн тухай нэг мөр өгүүлбэр буюу шүлэг зохиоход урь. Жишээ нь, “Миний хэлдэг зүйл үнэн байвал би хэзээ ч, хэзээ ч унахгүй!” Бичсэн өгүүлбэрээ бусад хүүхдүүдтэй хуваалцахыг анги бүрээс хүс. Шударга биш байхаар уруу татагдах бүрдээ энэ өгүүлбэрийг давтан хэлдэг байхад тэднийг урамшуулан дэмж.

Би Ариун Сүнснийг урьдаг зүйлсээр амьдралаа дүүргэхээр сонгосон.

Дуу: “Би Есүс шиг байхыг хичээдэг” (ХДН, 78–79)

Хэрэв ариун журамтай, сайхан, эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай ямар нэгэн зүйл байдаг бол бид эдгээр зүйлүүдийг эрэлхийлдэг” (Итгэлийн Тунхаг 1:13).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнснийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.



Түүхүүд: Түүх ярих нь хүүхдийн сонирхлыг татдаг бөгөөд үүнтэй холбоотой сургаалыг ойлгоход тусалдаг. Түүхүүдийг өөрийнхөө үгээр, сэтгэл хөдөлгөм сайн хуваалцаж сурах нь чухал юм.

Хэсгүүд: Хэрэв танай Хүүхдийн Хэсэг олон хүүхэдтэй бол хүүхдүүдийг хэсгээс хэсэгт шилжүүлэн нүүлгэхийн оронд удирдагчдыг нь зохицон нүүхэд анхаарал хандуул.

Нэгдэх долоо хоног: Сайн найзуудтай байх нь надад зөвийг сонгоход тусалдаг.

Ойлголтыг болон сургаалыг амьдралд хэрэгжүүлэх явдлыг урамшуулан дэмж.

(түүх сонс): Дараах түүхийг ярь: “Хоёр хөвгүүн замын хажуугаас элэгдсэн хуучин хос гутал олжээ. Нэлээд хол тариалангийн талбайд ажил хийж байгаа нэг хүнийг тэд олж харж. Нэг нь гутлыг нуугаад нөгөөх хүн яах нь вэ гэдгийг харъя гэжээ.” Тэд энэ хөвгүүнд юу гэж хэлэхээ хуваалцана уу гэж хүүхдүүдээс хүс. Тэгээд болсон явдлын үлдсэн хэсгийг ярьж өг: “Нөгөө хөвгүүн нь гутлыг нууж болохгүй харин хос гутал дотор нэг нэг мөнгөн зоос хийж орхье гэхэд тэд үүнийг хийжээ. Удалгүй

нөгөөх хүн эргэж ирэв. Тэрээр зооснуудыг хараад сэтгэл нь догдолж, өвдөг сөгдөн суугаад талархлын залбирал хэлсэн гэнэ. Тэр хүн өвчтэй эхнэрийнхээ тухай, идэх хоолгүй үлдсэн хүүхдүүдийнхээ тухай ярьж, өөрт нь тусалсан хүнийг адислахыг Их Эзэнээс гуйсан ажээ. Нөгөөх хоёр хөвгүүн зүрх сэтгэлдээ аятай сайхан мэдрэмжийг мэдрэч, зөвийг сонгосондоо баяртай байлаа” (Гордон Б.Хинкли, Conference Report, 1993 оны 4-р сар, 71; Ensign, 1993 оны 5-р сар, 54). Сайн найз нар нь зөвийг сонгоход тусалсан тохиолдлуудынхаа талаар хуваалцалцыг хэдэн хүүхдээс хүс.

Хоёрдахь долоо хоног: Би Тэнгэрлэг Эцэгийг баярлуулах зүйлсийг уншиж, сонсож, үзэж байх ёстой.

Сургаалыг тань (үзүүлэнт хичээл заа):

Дүүрэн жимстэй, дүүрэн шороотой хоёр аягыг хүүхдүүдэд үзүүл. Аль аягатайг идэхэд сайхныг бас яагаад гэдгийг хүүхдүүдээс асуу. Тэнгэрлэг Эцэг биднийг хор хөнөөлтэй зүйлсээр биш харин сайн зүйлсээр оюун ухаанаа дүүргэхийг хүсдэг гэдгийг тайлбарла. “Би Тэнгэрлэг Эцэгийг баярлуулах зүйлсийг уншиж,

сонсож, үзэж байх ёстой” гэсэн өгүүлбэрийг тэднээр хэлүүл. Энэ бол унших, сонсох, үзэх энгийн үйлдлүүд юм.

Ойлголтыг урамшуулан дэмж (сургаалыг ярилц): Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийг баярлуулахааргүй сонголтууд хийх юм бол маш чухал зүйлийг алдах болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол дахь “Үзвэр үйлчилгээ ба мэдээллийн хэрэгсэл” хэсгийн эхний догол мөрийг уншаад тэр чухал зүйлийг олохыг хүүхдүүдээс хүс (мөн “Миний сайн мэдээний жишгүүд”-ийг үз). Хэрэв бид буруу сонголт хийвэл юуг (Сүнснийг) алдана гэж сонссон бэ гэж хүүхдүүдээс асуу. Хүүхдүүдийг гурван бүлэгт хувааж, “Унших,” “Сонсох,” “Үзэх” гэсэн гурван өртөөн дээр ээлжлэн очихыг хүс. Тэнгэрлэг Эцэгийг баярлуулах ямар нэг зүйлийг буудал бүр дээр унших, сонсох буюу үзэхийг хүүхдүүдээс хүс. Бурханыг баярлуулах зүйлсийг уншиж, сонсож, үзэх нь тэдэнд ямар санагдсаныг ярилц.



Гуравдахь ба дөрөвдэх долоо хоног: Би Хүндэтгэлийн өдөр Тэнгэрлэг Эцэгтэй ойр байхад туслах зүйлсийг хийх ёстой.

Сургаалыг тань (судар цээжил): Чухал захиасыг таних нууцыг тайлах түлхүүрийг тэдэнд өгнө гэдгийг хүүхдүүдэд хэл. Египетээс гарсан нь 20:8-ын үг бүрийн эхний үсгийг самбар дээр бич (A Θ A C T C). Эдгээр үсгүүд бол судар дээрх үгсийн эхний үсгүүд гэдгийг тайлбарла. Мосегийн зураг болон Арван Зарлигийг үзүүлснээр дараагийн түлхүүрийг өг. Египетээс гарсан нь 20:8-ыг харж бүгдээрээ хамт уншихыг хүүхдүүдээс хүс. Самбар дээр байгаа болон судар дээр байгаа үсгүүдийн хоорондох холбоог олохыг хүүхдүүдэд даалга. Хүүхдүүдийг судрыг давтан унших зуураа самбар дээрх үсгүүд уруу заан судрыг цээжлэхэд нь тусал.

Ойлголтыг урамшуулан дэмж (ярилцаж, зургийг буд): Хүүхдүүдийг дөрвөн бүлэгт хуваа. Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлын “Хүндэтгэлийн өдөр баримтлах зүйл” хэсгийн нэг догол мөрийг бүлэг бүрт хуваарилж өг. Догол мөрийг бүлгээрээ ярилцаад сурч мэдсэн зүйлээ бусад хүүхдүүдтэй хуваалцахыг тэднээс хүс. Хүүхэд бүрд цаас өгч Хүндэтгэлийн өдөр хийх сайн зүйлсээ заримыг нь зурахыг тэднээс хүс. Хэдэн хүүхдээс зургаа Хүүхдийн Хэсгийн бусад хүүхдүүдэд үзүүлэхийг хүс. Сурч мэдсэн зүйлээ гэрийнхэнтэйгээ хуваалцахад нь тэднийг урамшуулан дэмж.

Ойлголтыг урамшуулан дэмж (судрын үйл ажиллагаа хий): Энэ үйл ажиллагаанд хэрэглэх маннаг төлөөлөх цаасаар дүүргэсэн сагсыг хичээлээс өмнө бэлтгэ. Дараах асуултуудыг самбар дээр бич:

Их Эзэн цөлд израилчуудыг ямар хүнсээр хангасан бэ? Тэд өдөр бүр хэчнээн хэмжээний маннаг түүдэг байсан бэ? Зургаа дахь өдөр тэд яах ёстой байсан бэ? Хүндэтгэлийн өдөр ямар ялгаатай байсан бэ?

Израилчууд маннаг түүсэн тухай түүхийг ярихдаа өмнөх асуултуудын хариуг хүүхдүүдээр олуул (Египетээс гарсан нь 16:11–31-ийг үз). Дээрх асуултуудын нэгнийг нь хариуг сонссон үедээ босохыг тэднээс хүс. Асуултанд хариулж байгаа түүхийн тэр хэсгийг нэг хүүхдээр дахин яриул. Тэгээд түүхийн үлдсэн хэсгийг үргэлжлүүл. Дууссан үедээ, Их Эзэн Хүндэтгэлийн өдөр манна түүхийг израилчуудаас яагаад хүсээгүй тухай хүүхдүүдтэй ярилц. Хүүхдүүдийг нүдээ аньж, унтаж байгаа дүр үзүүлэхийг хүс. “Маннаг” өрөөнд түргэн тарааж тавь. Хүүхдүүдийг нүдээ нээж, ноогдох маннаг (нэгээс хоёр ширхгийг) түүхийг хүс. Маннаг сагсанд буцааж хийхийг хүүхдүүдээс хүс. Бүх хүүхдийг маннагаа сагсанд хийсний дараа Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахих нэг арга замыг хуваалцахыг нэг хүүхдээс хүс.



Үйл ажиллагаануудыг Хүүхдийн Хэсгийн хэмжээнд тохируулан өөрчлөх нь илүү олон хүүхдийг оролцуулахад тусална. Хэрэв танай Хүүхдийн Хэсэг олон хүүхэдтэй бол хүүхдүүдийг жижиг бүлгүүд болгож хуваалуулахын тулд хэд хэдэн сагс бэлтгэж болно.



Зураг зурах: Сурч мэдсэн зүйлийнхээ тухай зураг зурах нь сургаалын тухай ойлголтоо бататгах боломжийг хүүхдүүдэд олгодог. Сурсан зүйлээ бататгахад нь хүүхдүүдэд туслахын тулд зургуудынхаа тухай гэрийнхэнтэйгээ ярилцахад тэднийг урамшуулан дэмж.



Хөгжмийн удирдагчид зориулсан тусламж

“Би Есүс шиг байхыг хичээдэг” (ХДН) дууг сурахад нь хүүхдүүдэд туслахын тулд дараах зүйлийг анхаарна уу.

- Дууг хүүхдүүдэд дуулж өг. Өөрийг чинь дуулах үед хичээдэг, хичээх гэсэн үг хэчнээн удаа дуулагдаж байгааг хуруу даран тоолохыг тэднээс хүс. Дууг та дахин дуулж өгөх үед хэмнэлд нь тохируулан алга ташихыг хүүхдүүдээс хүс.



Арван Зарлиг Бурханыг болон Түүний хүүхдүүдийг хайрлахыг надад заадаг

“Хэрэв чи намайг хайрладаг бол чи надад үйлчилж мөн бүх зарлигуудыг минь сахих ёстой” (С ба Г 42:29).




Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдэх долоо хоног: Бид зарлигуудыг сахиснаар адислагддаг.

Сургаалыг тань (үзүүлэнг хичээлийг үз): Хуваалцах цагт нялх хүүхдээ авчрахыг нэг ээжээс хүс. Нялх хүүхдийг аюулгүй, тайван байлгахад туслах зарим дүрмээс хуваалцахыг

хүүхдүүдэд хэл. Мосегийн зураг болон Арван Зарлигийг үзүүлж, Мосе эдгээр зарлигуудыг хэрхэн хүлээж авсныг хүүхдүүдэд товч ярьж өг (Египетээс гарсан нь 19–20-ийг үз).



Ойлголтыг урамшуулан дэмж (дуунууд дуул): Дараах гурван өгүүлбэрийг самбар дээр бич: “Бурханыг хүндэлж, бишрэн шүт,” “Эцэг эхээ хүндэл,” “Бусдыг хүндэл.” Арван Зарлигийг дээрх гурван хэсэгт хувааж болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдийг бүлэг болгон хувааж, дээрх гурван хэсгийн нэгэнд нь холбогдох нэг дууг бүлэг бүрт өг. Хэн нь дууг дуулахыг (жишээ нь, зөвхөн хөвгүүд, зөвхөн охид эсвэл улаан хувцас өмссөн хүүхдүүд гэхчлэн) бүлэг бүр өөрсдөө шийднэ гэдгийг хэл. Дууг дуулсны дараа уг дууг холбогдох хэсгийн дор тавихыг нэг хүүхдээс хүс. Дараах дуунуудыг дуулахыг хичээ: “Бямба гараг” (ХДН), “Би дуулгавартай дагана” (ХДН), “Аав минь” (ХДН), “Есүс Христийн Сүм” (ХДН 77), “Би элэгсэг нэгэн баймаар байна” (СДБХД, 63).



Жижиг бүлгүүд:

Хүүхдүүдийг бүлэг болгон хуваах нь тэднийг хичээлд илүү идэвхтэй оролцуулах үр өгөөжтэй арга зам мөн.

хүүхдүүдээс хүс. Бид бүгдээрээ Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд гэдгийг, Тэр бидэнд хайртай бөгөөд биднийг аюулгүй, аз жаргалтай байлгах дүрэм буюу зарлигуудыг өгснийг

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (дуу дуул): “Зарлигуудыг дага” (ХДН) дууг дуулж, бид зарлигуудыг дагавал ямар адислалууд амлагдсаныг сонсож мэдэхийг хүүхдүүдээс хүс. Зарлигуудыг сахивал тэд хэрхэн адислагдах тухай хуваалцахыг хүүхдүүдээс хүс.

Хоёрдахь долоо хоног: Би Бурханыг хүндэлж, шүтэн бишрэх ёстой.

Ойлголтыг болон судрыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (судруудыг унш): Тэнгэрлэг Эцэгээс Мосед өгсөн эхний дөрвөн зарлиг нь бид Бурханыг хүндэлж, шүтэн бишрэх ёстойг заадгийг тайлбарла. Дараах өгүүлбэрүүдийг самбар дээр бич. Судрын эшлэлүүдийг дөрвөн цаасан дээр бич.

1. Чи Надаас өөр бурхадтай ____ байж болохгүй. (Египетээс гарсан нь 20:3)
2. Чи өөртөө зориулан шүтэн бүү хий ____ _____. (Египетээс Гарсан нь 20:4)
3. Чи өөрийн Бурхан ЭЗЭНий нэрийг дэмий бүү дурд ____ _____. (Египетээс гарсан нь 20:7)

4. Амралтын өдрийг _____ ариунаар сахихын тулд санагтун. (Египетээс гарсан нь 20:8)

Хүүхдүүдийг дөрвөн бүлэг болгон хуваа. Бүлэг бүрд судрын нэг эшлэл өгч судрыг уншин, самбар дээрээс холбогдох өгүүлбэрийг олохыг тэднээс хүс. Эхний бүлгээс самбар дээрх хоосон зайг бөглөхийг хүсэж, бусад хүүхдүүдийг

өгүүлбэрийг хамтдаа давтан хэлэхэд нь удирд. Зарлигийн утгыг ярилцаж, уг зарлигийг дуулгавартай дагахын тулд юу хийж болохыг хүүхдүүдээр яриул. Тэдний санал зөвлөмжийг самбар дээр бич. Үүнийг үлдсэн гурван бүлэг дээр давтан хий. Ирэх долоо хоногт хэрэгжүүлэхийн тулд самбар дээрх зөвлөмжүүдээс нэгийг сонгож авахад хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Зөвлөгөө: Бичигдсэн хичээлүүд нь заадаг хүүхдүүдийн чинь хэрэгцээ, онцлогт тохирохгүй байж болно. Та хүүхдүүдийнхээ чадвар, нөхцөл байдлыг мэддэг учраас хуваалцах цагийн санаануудыг Хүүхдийн Хэсэгтээ тохируулан үр өгөөжтэй болгож чадна.

Гуравдахь долоо хоног: Би аав, ээжийгээ хүндлэх ёстой.

Сургаалыг тань (судрыг цээжил): Өнгөрсөн долоо хоногт судалсан зарлигуудыг товчхон давтаад, тэдгээр зарлигаар амьдрахын тулд хийсэн зүйлээ хуваалцахыг хэдэн хүүхдээс хүс. Хүүхдүүдийг дөрвөн бүлэгт хувааж, доор харуулсан зурвас цааснуудаас нэгийг бүлэг бүрт өг (Египетээс гарсан нь 20:12-ыг үз).

Эхний бүлгийг босч өөрсдийнхөө зурвас цаасан дээрх үгсийг давтан хэлээд суухыг хүс. Дараа нь бусад бүлгүүд ээлжлэн энэ үйл ажиллагааг хийнэ. Бүлгүүд зурвас цаасаа өөр бүлэгт өгч, бүх бүлэг зурвас цаасыг бүгдийг нь авч унших

хүртэл үйл ажиллагааг үргэлжлүүл. Бүх хүүхдийг босч зарлигийг хамтдаа давтан хэлэхийг хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (тоглоом тогло): Хүүхдүүдийг бүлгүүд болгон хуваа. Эцэг эхээ хүндлэхийн тулд хийж болох ямар нэг зүйлийг бодож олохыг бүлэг бүрээс хүс. Бүлэг бүрийг дохио зангаагаар үйлдэл хийж үзүүлэхийг уриад, тэд юуг харуулж байгааг бусад хүүхдүүдээр таалга. Тэднийг зөв таасан үед бүлгийн хүүхдүүдээс нэгийг нь санаагаа самбар дээр бичихийг хүс.

Эцэг эхээ хүндэл.

Тэгвэл чиний

Бурхан Эзэний чамд өгсөн газар дээр

чи урт наслах болно.

Зурвасуудыг sharingtime.lds.org -аас авч болно.

Дөрөвдэх долоо хоног: Би бусад хүмүүсийг хүндлэх ёстой.

Сургаалыг тань (хүндэтгэлийн тухай ярилц): Өнөөдөр Хүүхдийн Хэсэгт их чухал хүндтэй хүн ирэх болно гэдгийг хэл. Энэ хүнд хэрхэн хүндэтгэл үзүүлэхийг нь хүүхдүүдээс асуу. Тэр хүн хэн байж болохыг тэднээр таалга. Та хүүхэд болгонд цаасан од хатгаж өгөх явцдаа “Би Бурханы хүүхэд” дууг аяла. Хүн бүхэн чухал бөгөөд бид хүн бүрт хүндэтгэлтэй хандах ёстойг тайлбарла. Арван Зарлигаас нэлээд хэд нь бусдыг хэрхэн хүндлэх тухай бидэнд заадгийг хүүхдүүдэд хэл.

Ойлголтыг урамшуулан дэмж (жишээнүүдийг ярилц): Арван Зарлиг бидэнд хулгай хийхгүй, худал хэлэхгүй байхыг заадаг. Энэ бол бид бусдыг хүндлэх нэг арга зам мөн гэдгийг тайлбарла. Шударга байх талаар хүүхдүүдийн гаргадаг сонголтын нөхцөл байдлыг харуулсан нэлээд хэдэн жишээ бэлтгэ (TNGC, 161–62-ыг

үз) Хүүхдүүдийг бүлэг болгон хуваагаад бүлэг бүрт цөөн хэдэн жишээ өг. Жишээ бүрийг уншиж, тэд нөхцөл бүрт хэрхэн шударга байж болохыг ярилцахыг тэднээс хүс.

Хүүхэд бүрт хайраа харуулах боломжуудыг эрж хай. Зааж байгаа хүүхдүүддээ хайраа харуулбал тэд Сүнсийг илүү ихээр мэдэрч, сурч байгаа зүйлдээ илүү идэвхтэй байх болно (TNGC, 31-ийг үз).



Санваарын адислалууд бүх хүмүүст боломжтой

Асуултууд: Үр дүнтэй асуултууд асуух нь хүүхдүүдийг оновчтой сайн хариулт өгөхөд нь тусална. Зөвхөн тийм, үгүй гэж хариулах асуултаас зайлсхий.



Зөвлөгөө: Хүүхдүүдийн гэр бүлийн нөхцөл байдал мэдрэмтгий ханд. Санваар нь хүйс харгалзахгүйгэр хүн бүрийг адисална гэдгийг түүнчлэн гэртээ санваартан байхгүй хүүхдүүд ч гэсэн гэрийн багш нар болон бусад хамаатан садныхаа ах нар мөн Сүмийн удирдагчдаас санваарын адислал авч болно гэдгийг онцолж хэл.

Үзүүлэнт хичээлийг хүүхдүүдийн сонирхлыг татаж, анхаарлыг нь төвлөрүүлэх буюу сайн мэдээний зарчмыг танилцуулахад ашиглаж болно (TNGC, 164-ийг үз).

“Мөн тэрчлэн энэхүү санваарыг хүлээн авдаг тэд бүгд намайг хүлээн авдаг хэмээн Их Эзэн хэлдэг” (С ба Г 84:35).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Нэгдэх долоо хоног: Зохистой залуу эрэгтэйчүүд 12 нас хүрсэн үедээ санваар авдаг.

Сургаалыг тань (зураг үз): Ариун ёслолыг үндэслэн бий болгож байгаа Есүс Христийн зургийг хүүхдүүдэд үзүүл. Христ Мормоны Номонд ариун ёслолыг Өөрийн Төлөөлөгчид, болон шавь нартаа өгч, Түүнийг тэнгэрт өргөгдөн явсаны дараа ариун ёслолыг адислан, түгээхийг үргэлжлүүлж байхыг хүссэнийг тайлбарла. 3 Нифай 18:5–6-г хамтдаа унш. Өнөө үед ариун ёслолыг хэн адисалдаг вэ? Ариун ёслолыг хэн түгээдэг вэ? Ариун ёслолыг адисалж, түгээх хүн ямар эрх мэдэлтэй байх хэрэгтэй вэ? гэх мэт асуултуудыг хүүхдүүдээс асуу.

Ойлголтыг урамшуулан дэмж (сургаалын тухай ярилцана): Санваар бол дэлхий дээрх хүмүүст үйлчилж, тэднийг адислах Бурханы хүч гэдгийг тайлбарла. Дараах хоёр шаардлагыг хангадаг ямар ч эрэгтэй хүн санваартай байж болно гэдгийг Христ бидэнд хожмын өдрүүдэд заасан юм. Эхнийх нь тодорхой насанд хүрсэн байх ёстой. Эрэгтэй хүүхэд санваар авахын тулд хэдэн настай байх ёстой вэ? гэж хүүхдүүдээс

асуу. Нэгээс арванхоёр хүртэл аажуухан тоол. Хоёр дахь шаардлага бол уг хөвгүүн зохистой байх явдал мөн гэдгийг хүүхдүүдэд хэлж өг. Зохистой байна гэдэг нь юу гэсэн үг болохыг мөн хэрхэн зохистой амьдрахыг мэдэхийн тулд хөвгүүд, охид “Миний сайн мэдээний жишгүүд”-ийг ашиглаж болно гэдгийг тайлбарла.


Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (спортын үйл ажиллагаанд оролц): Хүүхдүүдийг бүлгүүд болгон хуваа. Бүлэг болгонд “Миний сайн мэдээний жишгүүд”-ээс нэг жишгийг хуваарилж өг. Жишгүүдийг нь дүрслэн харуулах энгийн үйлдлийн тухай бодохыг бүлэг бүрээс хүс. Аль нэг жишгийг сануулах хэдэн үг хэлээд даалгавар өгсөн бүлгийг босч, үйлдлээр үзүүлэхийг хүс. Бүх бүлгийг хамартал үйл ажиллагааг үргэлжлүүл. Эдгээр жишгээр амьдрах нь хөвгүүдийг санваар атгах болон, санваарын адислалуудыг хүлээн авах зохистой байхад нь харин охидыг баптисм болон ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад зохистой байхад нь тусална гэдгийг тайлбарла.

Хоёрдахь долоо хоног: Бид санваараар дамжуулан авралын ёслолуудыг хүлээн авдаг.



Сургаалыг тань (үзүүлэнт хичээлийг үз): Нэг хүүхдээр дэлгэсэн шүхрийг бариул. Хоёр гурван хүүхдийг шүхэрний дор зогсоо. Шүхрийг санваартай харьцуул. Хэрэв бороо орох юм бол зөвхөн шүхрийг барьж байгаа хүүхэд төдийгүй шүхэр дор зогсож байгаа бүх хүүхэд бороонд норохгүй байх адислалыг авна гэдгийг онцлон тэмдэглэ. Үүнтэй адилхан Бурхан санваараар дамжуулан бүх хүүхдээ адислагдах боломжоор хангадаг. Бид санваараар дамжуулан Бурхан уруу эргэн очиж, Түүнтэй дахин хамт амьдрах боломжийг олгодог авралын ёслолуудыг хүлээн авдаг.

Ойлголтыг урамшуулан дэмж (эвлүүлдэг тоглоом тогло): баптисм, гишүүний баталгаа, санваарын ёслол (эрэгтэйчүүдэд), ариун сүмийн хишиг, мөн ариун сүмийн лацдан холболт гэсэн үгсийг тус бүрд нь цаасан дээр бич. Цаас бүрийг эвлүүлэх таавар болгон хайчил. Ёслол гэж юу болохыг (сүнслэг утгатай ариун ёслол буюу зан үйл) хүүхдүүдэд товч тайлбарлаад, Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очин, Түүнтэй хамт амьдрахад



бидэнд санваарын ёслолууд шаардлагатайг хэл. Самбар дээр хөлийн таван мөр зураад хамгийн дээд мөрөн дээр Есүс Христийн зургийг байрлуул. Хүүхдүүдийг таван хэсэг болгон хуваагаад хэсэг бүрд нэг цаас өг. Эвлүүлэх тааврыг нийлүүлж, ёслолын тухай мэдсэн зүйлээ Хүүхдийн Хэсгийн үлдсэн хүүхдүүдтэй хуваалцахыг тэднээс хүс. Бүлгүүдийг эвлүүлсэн таавраа дэс дараагаар нь самбар дээрх хөлийн мөрөн дээр байрлуулахыг хүс.



Зурвасыг sharingtime.lds.org-аас авч болно.

Гуравдахь долоо хоног: Би санваарын адислалуудаар дамжуулан итгэлээ бэхжүүлэх хүчтэй болж чадна.

Сургаалыг тань (сургаалын талаар яриуц): Хүүхдүүдийг гараа өргөж, гар уруугаа харахыг хүс. Тоглох, ажил хийх, сүмд явахгаар бэлтгэхэд нь гар ямар хэрэгтэй талаар тэднээс асуу. Хариулт бүрийг хөдөлгөөнөөр дүрсэлж харуулахыг урь. Хүмүүс бусдад туслахын тулд гараа хэрхэн ашиглаж болохыг тэднээс асуу. Санваартнууд бидэнд тусалж, биднийг хүчирхэгжүүлдэг адислалыг өгөхийн тулд гараа ашигладгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (зургууд харж, туршлагаа хуваалц): Ариун ёслол, баптисм, гишүүний баталгаа, хүүхдийг адислах, өвчтөнд адислал өгч байгаа зургуудыг тасалгаанд байрлуулж, зураг бүр дээр юу болж байгааг тайлбарла. Хүүхдүүдийг хоёр гараа цаасан дээр тавьж тойруулан зураад, гарын дүрсээ хайчилж авахыг хүс. Хайчилж авсан гарын хэвнийхээ өмнө талд нэрээ бичихийг тэднээс хүс. Хайчилж авсан гарын хэвнийхээ нэгийг санваартны гараас өөрсдийн хүлээн авсан адислал буюу ёслолыг

дүрсэлсэн зургийн хажууд наахыг тэднээс хүс. Гарын хэдэн хэвийг сонгож аваад санваар тэдгээр хүүхдүүдийг хэрхэн адисалж, итгэлийг нь бат бөх болгосон тухай санаа бодлыг нь хуваалцуул. 3 Нифай 17:11–25 дахь хүүхдүүдийг адисалж байгаа Есүсийн тухай түүхийг ярьж өг. Хүүхдүүдтэй хамт байгаа Есүсийн зургийг ангийн өмнө байрлуулж, гарынхаа хоёр дахь хэвийг зургийн ойролцоо байрлуулахыг бүх хүүхдээс хүс. Санваартнууд Есүс Христийн нэрээр үйлдэх хүчтэй байдгийг, хэрэв Есүс дэлхий дээр байсан бол биднийг яаж адислах байсан тийм байдлаар тэд биднийг адисалж чаддагийг тайлбарла.



Хичээлд идэвхтэй оролцоход хүүхдүүдэд туслах нь зааж байгаа сургаалыг тань өөрийн болгож эзэмшихэд нь тэдэнд тусална.

Дөрөвдэх долоо хоног: Би том болохоороо өвөг дээдсийнхээ өмнөөс ёслолуудыг авахаар ариун сүмд очиж чадна.

Сургаалыг тань, ойлголтыг урамшуулан дэмж (зураг буд): Бид Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очин Түүнтэй хамт амьдрахаас өмнө санваарын адислалуудыг авах хэрэгтэй гэдгийг хүүхдүүдэд сануул. Эдгээр ёслолуудаас заримыг нь нэрлэхийг тэднээс хүс. Олон хүмүүс эдгээр ёслолуудыг хүлээн авах боломжгүй байсаар нас барсныг болон тэдэнд бидний тусламж хэрэгтэй байдгийг тайлбарла. Эдгээр ёслолуудыг авалгүйгээр нас барсан өвөг дээдсийнхээ нэгнийх нь тухай хүүхдүүдэд ярь. Цаасаар хайчилж хийсэн хүний дүрсийг

хүүхэд бүрд өг. Цаасны нэг тал дээр өөрсдийгөө, нөгөө тал дээр нь өөрийнхөө ярьсан өвөг дээдсийнхээ нэгний зургийг зурахыг тэднээс хүс. (Хэрэв хүүхдүүд санваарын ёслолуудыг хүлээн авалгүйгээр нас барсан өвөг дээдсийнхээ хэн нэгнийг мэддэг бол тэр хүнийг зурж болно.) Хүүхдүүдээр цаасан хүний дүрсийг бариулж, энэ долоо хоногийн сэдвийг давтан хэлүүл. “Би” гэдэг үгийг хэлэхэд өөрсдийнхөө зургийг, “өвөг дээдэс” гэдэг үгийг хэлэхэд өвөг дээдсийнхээ зургийг харуулахыг тэднээс хүс.

Би одоо номлогч болохоор сонгож чадна

“Есүс тэдэнд, Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагтун гэж айлдлаа” (Марк 16:15).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. **“Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнсийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.**

Нэгдэх долоо хоног: Би бусдад үйлчилснээр номлогч болж чадна.

Ойлголтыг урамшуулан дэмж (жүжигчлэн заах): Матай 25:34–40-ийг уншиж, бусдад үйлчлэх нь Тэнгэрлэг Эцэгтэй үйлчилж байгаа хэрэг гэдгийг (Мозая 2:17-г үз) мөн энэхүү үйлчлэл нь бидэнд аз жаргалыг авчирч,

Бурхантай дахин амьдрах боломжийг олгоно гэдгийг тайлбарла. Зарим үйлчлэлийг, жишээ нь өлссөн хүнд хоол өгөх, ганцаардсан хэн нэгэнд найз нь болох, өвчтэй хүнийг эргэж очих зэрэг үйлчлэлийг хэдэн хүүхдээр жүжигчлэн тоглуул. Жүжигчилсэн тоглолт бүрт юу болж байгааг бусад хүүхдүүдээр таалга. Номлогчдын зургийг үзүүл. Номлогчид Бурханд хэрхэн үйлчилдэгийг асуу. Бид бусдад үйлчилснээрээ бас номлогчид болдгийг тайлбарла.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (тоглоом тогло): Есүсийн зураг уруу хөтөлсөн замтай, зургаан өөр өнгөтэй хөлөгт тоглоом хий. Хөлөгт тоглоомон дээрх зургаан хэсгийн өнгийг зааж тохируулах

хөдөлгөөнт сум бэлтгэ. Өнгө бүр дээр эцэг эх, найз, хөрш гэхчлэн хүүхдүүдийн үйлчилж болох нэг хүний нэрийг бич. Хөдөлгөөнт сумыг нэг хүүхэд эргүүлэхэд сум хэний нэр дээр зогсоно тэр түүнд хэрхэн үйлчлэхээ хэлнэ. Тэгээд тэр хүүхэд дүрсийг хөлөгт тоглоомон дээрх өөр өнгөтэй дараагийн тэгш өнцөгтөд шилжүүлнэ. Тоглоомын дүрс Аврагчийн зурагт хүртэл бусад хүүхдүүдээр давтан үргэлжлүүл. Бид бусдад үйлчилж байгаа нь Бурханд үйлчилж байгаа хэрэг гэдгийг хүүхдүүдэд сануул. “Бид тусалж байхдаа” дууг дуул (CS, 198).



Хөлөгт тоглоом болон хөдөлгөөнт сум нь sharingtime.lds.org-т байгаа.

Тоглоом: Тоглоом нь хичээлийг олон хэлбэртэй болгохын сацуу хүүхдүүдэд хамтран ажиллах, сайн мэдээний зарчмыг хөгжилтэй арга хэлбэрээр сурах боломж олгодог.

Сэтгэн бодох чадвараа ашиглахад нь хүүхдүүдийг дэмж. Хүүхдийн насанд тохирсон асуултуудыг асуух буюу сурч мэдэх үйл явцыг дээшлүүлдэг зүйлсээр тэдний оюун ухааныг хөгжүүл.

Хоёрдахь долоо хоног: Би сайн үлгэр жишээ үзүүлснээр номлогч байж чадна.

Сургаалыг тань (үзүүлэнт хичээл заа): Хүүхдийн Хэсгийн хичээлээс өмнө шоогоор барилга өрж, хүүхдүүд харахгүй газарт юмаар бүтээ.

(Хэрэв шоо олдохгүй бол самбар дээр зураг зурж, зургийг цаасаар

бүтээ.) Харагдахгүйгээр бүтээсэн барилгыг болон түүнийг хэрхэн барьснаа дүрслэн ярь. Тэгээд хэдэн хүүхдэд хэсэг шоо өгөөд өөрийнхөө барьсантай адилхан барилга барихыг тэднээс хүс. Тэднийг дуусахад барилгын бүтээлгийг авч хоёр барилга ямар ялгаатай байгааг ажиглуул. Өөрийн тань барилгын загварыг харж байгаад барилгаа дахин барихыг хүүхдүүдээс хүс. Жишээ загварыг нь харж байгаад хийхэд олон зүйл амархан байдгийг тайлбарла.



Ойлголтыг урамшуулан дэмж (түүх сонсож, дуу дуул): залуу хүмүүс сайн үлгэр жишээ үзүүлсэн түүхийн зургийг үзүүлж, үйл явдлыг товчхон ярьж өг (жишээ нь, Даниел болон түүний найз нар хааны дарснаас уухыг татгалзсан тухай) [Даниел 1:5–16]; Шадрах, Мешах, Абеднего нар [Даниел 3:4–29]; мөн Даниел арслангийн үүрэнд [Даниел 6]-г үз. Номлогчдын зураг үзүүлж, номлогчид сайн үлгэр жишээ хэрхэн үзүүлдгийг хүүхдүүдээс асуу. Бид сайн үлгэр жишээ үзүүлсэн үед бидний үлгэр жишээ Есүс Христийн тухай илүү ихийг мэдэхийг хүсэхэд нь бусад хүмүүст тусалж болох учраас



бид номлогчид болдог гэдгийг тайлбарла. Танай тойрог буюу салбарт хүүхдүүд сайн үлгэр дуурайл үзүүлсэн тохиолдлын тухай хуваалц.

“Үргэлж гэрэлт” (ХДН) дууг дуулахыг хүүхдүүдээс хүс. Тэднийг дуулж байх үед цаасан нарыг нэг нэгэндээ дамжуулж өгөхийг хүс. Хөгжим зогсох бүрд нарыг барьж байгаа хүүхдээс хэрхэн сайн үлгэр жишээ үзүүлж болохыг асуу (жишээ нь, бусадтай найрсаг харилцах, үнэнийг хэлж байх, найз нараа Хүүхдийн Хэсэгт урих гэх мэт). “Би гэрлээрээ үлгэр жишээ үзүүлж чадна” гэсэн үгстэй өөрийнхөө нарыг цаасаар хийхийг хүүхэд бүрээс хүс. “Би од шиг” (ХДН), “Есүс намайг нарны туяа шиг байгаасай гэж хүсдэг” (ХДН 60–61) эсвэл “Үргэлж гэрэлт” (ХДН) дуунуудыг дуулах үед нарыг нь хүүхдүүдээр өргөж харуул.



Гуравдахь долоо хоног: Би найз нартаа Есүс Христ болон Түүний Сүмийн тухай зааж чадна.

Сургаалыг тань (үйлдлээр харуулах замаар): Нэг буюу түүнээс олон хүүхдийн гарыг барьж, тэднийг Хүүхдийн Хэсэгт ирж, Есүсийн тухай мэдэхийг урьж байгаа жүжигчилсэн тоглолт хий. Урилгыг хүлээн авсан хүүхдүүд бусад бүх хүүхдээ урьж дуустал зааварчил. Биднийг найз нартаа Есүс Христ болон Түүний Сүмийн тухай зааснаар номлогчид болохыг Их Эзэн хүсдэгийг тайлбарла.

Ойлголтыг урамшуулан дэмж (түүх сонс): Сайн номлогч байсан Хүүхдийн Хэсгийн нэгэн хүүгийн талаарх Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын хэлсэн түүхийг хуваалц: Галт тэргэнд явж байсан нэгэн хүн хүүгээс Мормон Сүмийн талаар асуужээ. Тэр хөвгүүн Итгэлийн Тунхагийг бүхэлд нь эш татсан гэдэг. Өөрийнх

нь итгэдэг байсан зүйлийг энэ хөвгүүн мэдэж байсанд нөгөө хүн сэтгэл нь их хөдөлж, Сүмийн тухай улам ихийг мэдэхийн тулд Солт Лейк хот уруу явсан гэдэг (Conference Report, 1975 оны 10-р сар, 117–19; Ensign, 1975 оны 11-р сар, 77–79-ийг үз). Итгэлийн Тунхагийг суралцах нь одооноос номлогчид болоход бидэнд тусалж чадна гэдгийг тайлбарла.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (Итгэлийн Тунхгийг дахин давт): 11–13 хүртэл дугаарласан 13 ширхэг цаас бэлтгэ. Хүүхдүүдийг бүлгүүд болгон хуваа. Бүлэг бүрээр нэг цаас сонгуулж, сонгосон дугаартай нь тохирох итгэлийн тунхгийг судлуул. Бүлгүүд бэлэн болоход сонгосон тунхгийг нь цээжээр уншуул. Тэгээд дахиад нэг цаас сонгуул. Цаг байвал энэ мэтээр үргэлжлүүл.

Дөрөвдэх долоо хоног: Би номлолд үйлчлэхээр одооноос эхлэн бэлтгэж чадна.

Сургаалыг тань (номлолын ажилтай холбоотой зүйлсийг үзүүл): Ням гарагт өмсдөг гутал, зангиа, судрууд гэх мэт бүрэн цагийн номлогчдын хэрэглэдэг зүйлсийг хийсэн жижиг цүнх буюу чемодан бэлтгэ. Нэг юм уу хоёр хүүхдийг цүнхнээс эд зүйлсийг гаргаж, үлдсэн хүүхдүүдэд үзүүлэхийг хүс. Зөвхөн эдгээр зүйлсийг бэлдсэнээр номлогч болоход бэлэн болдог уу? гэж хүүхдүүдээс асуу. Сургаал ба Гэрээ 84:62-ыг уншиж өгөөд, номлогч болгонд хэрэгтэй өөр нэг зүйлийг (гэрчлэл) сонсож олохыг хүүхдүүдээс хүс. Хувийн гэрчлэлтэй болохын ач холбогдлыг гэрчил.

Ойлголтыг урамшуулан дэмж (зураг үзэж, асуултуудад хариул): Гэрчлэлийн чухал хэсгүүдийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Тэдгээр хэсгийг дүрсэлсэн зургуудыг үзүүл (жишээ нь, Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай, Есүс Христ бол бидний Аврагч, Иосеф Смит бол бошиглогч, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол Их Эзэний үнэн Сүм, биднийг амьд бошиглогч удирддаг). Энэ юу вэ? Энэ хэн бэ? гэхчлэн зураг бүрийн талаар хэд хэдэн асуулт асуу? Энэ тухай та нар юу мэдэх вэ? Та нар энэ тухай гэрчлэлээ хэрхэн бэхжүүлж болох вэ? Гэрчлэлээ хуваалцаж болох хүмүүсийг нэрлэхийг хүүхдүүдээс хүс. Хүүхдүүд мэддэг зүйлээ бусадтай хуваалцахын хэрээр гэрчлэл нь өсч бэхжин, номлолд үйлчлэхэд бэлтгэгдэх болно гэдгийг гэрчил.

Зөвлөгөө: Хуваалцах цагийн аль нэг хичээлд нэмэлт болгон сар бүр судраас суралц. Та бас Хүүхдийн Хэсгийн өрөөнд сар тутмын сэдвийг тавьж болно.

Үйл ажиллагааны эхэнд хүүхдийн анхаарлыг татах арга замуудыг төлөвлө. Жишээ нь, энэ үйл ажиллагаанд хүүхдүүд цүнхнээс юу гарч ирэх бол гэж сонирхох болно.



Есүс Христ бол Бурханы Хүү

“Болгоогтун, би бол Есүс Христ, Бурханы Хүү. Би бол дэлхийн амьдрал ба гэрэл билээ” (С ба Г 11:28).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Долоо хоног бүр (1) сургаалыг таних арга замуудыг төлөвлө, (2) сургаалыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал, (3) тэдэнд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь тусал. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Ариун Сүнснийг мэдрэхэд нь би тэдэнд хэрхэн туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.



Түүх ярихад хүүхдүүдийг оролцуулах нь тэдний сонирхлыг татаж, хичээлд идэвхтэй оролцох боломж олгоно.



Энэ үйл ажиллагаагаар хүүхдүүд Есүс Христийн адилаар өсч хөгждөгийг ойлгосноор Түүнтэй ижил гэдгээ мэднэ.



Нэгдэх долоо хоног: Тэнгэрлэг Эцэг Хүүгээ дэлхий уруу илгээсэн.

Сургаалыг тань (үйл ажиллагаанд хэрэглэх шүлгийг давт): Үйл ажиллагаанд ашиглах дараах шүлгийг хүүхдүүдтэй хамт хэд, хэдэн удаа давт:

Тэнгэрлэг Эцэг Хүүгээ дэлхий уруу илгээсэн. Тэрбээр ирэхдээ нялх хүүхэд байлаа. (өлгийтэй хүүхэд тэвэрч байгааг дүрслэн харуул) Тэр та нартай бас надтай адилхан өсч том болсон. (бэлхүүсээрээ бөхийгөөд ажухан бос) Тэр бидэнд хайртай учраас (зүрхэн дээрээ гараараа дар) бидний төлөө нас барсан юм. (суу) Тэр амилсан учраас бид дахин амьдарна! (дахин бос)

Судруудад Есүс өөрийгөө Бурханы Хүү гэдгээ бидэнд хэлсэн байдаг. Сургаал ба Гэрээ 11:28-ыг

хамтдаа чанга унш. (Та судрын энэ хэсгийг уншихдаа бага насны хүүхдүүдээр зөвхөн “Бурханы Хүү” гэж хэлүүлж болно.)

Ойлголтыг урамшуулан дэмж (зураг зурж, түүх сонсоно): Есүс Христийн төрөлтийн түүхээс аль нэг үйл явдал буюу хүнийг хүүхэд бүрээр зуруул (жишээ нь, Мариа, Иосеф, хоньчид гэх мэт). Лук 2:4–17, Матай 2:1–12 дахь түүхүүдийг дахин ярьж өг. Түүхийн холбогдох үед зургаа өргөж харуулахыг хүүхдүүдээс хүс. Энэ үйл ажиллагааны үед та Children’s Songbook-ээс Христийн Мэндэлсний Баярын дуунуудаас дуулахыг хүсч болно (хуудас 34–54-ийг үз). Хүүхдийн Хэсгийн хичээл заахад хөгжим ашиглах тухай зөвлөмжийг TNGC, 172–75-аас үзнэ үү.

Хоёрдахь долоо хоног: Есүс мэргэн ухаан болон бие бялдраараа өсч хөгжин, Бурханы тааллыг олж, хүмүүстэй дотно байлаа.

Сургаалыг таниул (дуу дуулж, судар цээжлүүл): Нялх балчраас хүүхэд, хүүхдээс насанд хүрсэн Христийн өсөж том болсон тухай зургуудыг үзүүл.

“Есүс бяцхан хүүхэд байсан юм” (CS) дууг хамтдаа дуулж энэ дуу Есүсийн тухай юу зааж байгааг тайлбарлахыг хүүхдүүдээс хүс. Лук 2:52-ыг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусалж, Есүс мэргэн ухаанаар (толгой уруугаа заах), бие бялдраар (булчингаа зангидаж харуулах) өсч хөгжин,


Бурханы тааллыг олж (гараа цээжээрээ зөрүүлэх), хүмүүстэй дотно (найз уруугаа даллах) байсныг харуулахын тулд энгийн үйлдлүүдийг ашигла.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (судрууд уншиж, үйл ажиллагаанд оролц): Ангийн талбайг дөрвөн хэсэг хувааж, дараах тэмдгүүдээс аль нэгийг хэсэг бүрд тавь: Есүс мэргэн ухаанаар өсч хөгжиж байв — С ба Г 88:118; Есүс бие бялдраараа өсч байв — С ба Г 89:20; Есүс Бурханы тааллыг олсон юм — С ба Г 88:63; Есүс хүмүүстэй дотно байв — Сургаалт Үгс 18:24. Тэнгэрлэг Эцэг болон Түүний зарлигуудын тухай хүүхдийн насанд тохирсон асуултууд тавих (мэргэн ухаан), метрээр хүүхэд бүрийн өндрийг хэмжиж, эрүүл хүнсний зургуудтай цаас үзүүлэх (бие бялдарын хөгжил), Найз эсвэл Лиахона сэтгүүлээс гэрчлэл, нөхөрлөлийн тухай түүхүүд (“Бурханд ойр,” “хүмүүстэй дотно байв”) зэрэг хэсэг бүрд зориулсан энгийн үйл ажиллагааг бэлтгэ. Бид бүгд Есүсийн адилаар “бие болон мэргэн ухаанаар өсч, Бурханд ойр, хүмүүстэй дотно байна” (Лук 2:52)

гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг дөрвөн бүлэгт хувааж, дээрх гэмдгүүдийн нэгэнд бүлэг бүрийг хамтдаа судар уншиж, үйл ажиллагаанд

оролцоход нь удирдахыг насанд хүрэгч нэг хүнээс хүс. Хүүхдүүдийг нэг тэмдгээс нөгөө уруу шилжих цаг болоход намуухан хөгжим тогло.

Давтлага: Арванхоёрдугаар сар бол сурч мэдсэн зүйлээ давтан бататгахад нэн тохиромжтой сар юм. Өмнөх хичээлийн үйл ажиллагааг давтахдаа энэ долоо хоногт ямар байдлаар амьдарснаа хуваалцахыг хүүхдүүдээс хүсэх буюу уг сургаалыг гэрийнхэнтэйгээ хэрхэн хуваалцсаныг нь асуу.



Нарны зураг
sharingtime.lds.org-т байгаа.

Гуравдахь долоо хоног: Есүс Христ бол дэлхийн гэрэл ба амьдрал мөн.

Сургаалыг тань (судрын үйл ажиллагааг хий): Христийн төрөлтийн болон үхлийн тухай зургуудыг өрөөний хоёр талын хананд байрлуул. Есүсийн төрөлтийн эсвэл Түүний үхлийн тэмдгийн тухай судруудаас уншиж өгнө гэдгээ хүүхдүүдэд хэл. Өөрийн чинь уншсан судрын тухай өгүүлж байгаа зураг уруу харахыг хүүхдүүдээс хүс. (Хэрэв танай Хүүхдийн Хэсэг цөөхөн хүүхэдтэй бол тэднийг зураг уруу очуулж болно.) 3 Нифай 1:15, 19, 21; 8:20, 22–23-ыг унш. Есүс Христ дэлхийд гэрлийг хэрхэн авчирсан тухай ярилц. Хүүхдүүдийг нүдээ аньж, гэрэлгүй амьдрах боллоо гэхэд ямар бэрхшээл тулгарч болохыг төсөөлөн бодохыг хүс. Хэрэв бидэнд Есүс Христийн сайн мэдээ байгаагүй бол бидэнд тохиолдож болох бэрхшээлүүдийг харанхуйн бэрхшээлтэй харьцуул. Иохан 8:12-ыг уншиж, бид харанхуйд алхахгүй байж болохын тулд юу хийх ёстойг сонсож мэдэхийг хүүхдүүдээс хүс.

Ойлголтыг урамшуулан дэмж (таах тоглоом тогло): Есүс бол дэлхийн гэрэл гэдгийг санахад бидэнд туслах олон бэлгэдэл байдгийг, эдгээр бэлгэдлээс заримыг нь Христийн Мэндэлсний Баяраар ашигладгийг тайлбарла. Эдгээр бэлгэдлээс заримыг нь (лаа, цаасан од, гэрэл зэрэг) цүнхэнд хийж бэлтгэ. Нэг хүүхдийг цүнхэнд гараа оруулж, нэгийг харалгүйгээр тэмтэрч үзээд юу болохыг тааж, цүнхнээс гаргаж бусад хүүхдүүдэд үзүүлэхийг хүс. Есүс Христ бидний амьдралд гэрлийг авчирсан ямар нэг зүйлийн тухай хуваалцахыг уг хүүхдээс хүс. Энэ мэтээр бусад юмс дээр үргэлжлүүлэн ажилла.


Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (зураг зур): Хүүхэд бүрд цаасан нар өг. Есүс Христийн гэрлийг дагах нэг арга замын тухай тэднээр бичүүлэх буюу зураг зуруул. Зургаа гэрийнхэнтэйгээ хуваалцахад нь урамшуулан дэмж.

Дөрөвдэх долоо хоног: Иосеф Смит Есүс Христийг харж, Түүний тухай гэрчилсэн.

Ойлголтыг урамшуулан дэмж (бэлгүүдийг нээж харуул): Анхны Үзэгдлийн зургийг бэлэг болгож боо. Олон хүмүүс хэн нэгний төрсөн өдрөөр бэлэг өгдгийг тайлбарла. Бид Христийн Мэндэлсний Баяраар хэний төрсөн өдрийг тэмдэглэдгийг асуу. Арванхоёрдугаар сард өөр нэг чухал хүний төрсөн өдөр байдгийг хэл. Нэг хүүхдийг бэлгийг задалж тэр хүн хэн болохыг хэлэхийг хүс. Арванхоёрдугаар сарын 23 бол Иосеф Смитийн төрсөн өдөр гэдгийг хүүхдүүдэд хэл. Анхны Үзэгдлийн тухай ярилцаж, Иосеф Смит Есүс Христийг харж, Түүний тухай гэрчилснээр бидэнд чухал бэлэг өгсөн юм гэдгийг тайлбарла. “Иосеф Смит Есүс Христийг харж, Түүний тухай гэрчилснээр бидэнд бэлэг өгөгдсөн юм” гэж самбар дээр бич. Дөрвөн том цаас бэлтгэж, цаас бүр дээр дараах бэлгүүдийн нэгийг бич. “Бидэнд Мормоны Ном бий.” “Өнөөдөр дэлхий дээр бидэнд үнэн Сүм бий” “Бидэнд санваар байдаг” “Тэнгэрлэг Эцэг залбирлыг маань сонсож, хариулдгийг бид мэднэ.”

Хүүхдүүдийг дөрвөн бүлэг болгон хуваа. Бүлэг бүрт цааснуудын нэгийг өгч, тэр бэлгийн тухай зурахыг хүс. Зурсан зургаа өөр бүлэгт бэлэг болгон өгөхийг тэднээс хүс. Бэлгээ бусад хүүхдүүдэд үзүүлж, тайлбарлаад, самбар дээр байрлуулахыг бүлэг бүрээс хүс.

Сургаалыг амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулан дэмж (Есүс Христийн тухай гэрчил): Хүүхдүүдийн нүдийг аниулж, сайн мэдээний бэлгийг хуваалцаж болох хэн нэгний тухай бодохыг хүс. Тэд Иосеф Смиттэй адилхан Есүс Христийн тухай гэрчилж болно гэдгийг тайлбарла.



Иосеф Смит Есүс Христийг харж, Түүний тухай гэрчилснээр бидэнд бэлэг өгөгдсөн юм.

Бидэнд Мормоны Ном бий.



Өнөөдөр дэлхий дээр бидэнд үнэн Сүм бий.



Бидэнд санваар байдаг.



Тэнгэрлэг Эцэг залбирлыг маань сонсож, хариулдгийг бид мэднэ.



Зурвасуудыг
sharingtime.lds.org- аас авч болно.



Сайн мэдээний зарчмуудыг бататгах

нь: Хуваалцах цагаар дуу заах нь Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн заадаг зарчмуудыг бататгахад тусална. “Дуу хөгжим бол таны хичээлд Их Эзэний Сүнсийг урих шилдэг арга зам мөн. Үгээр илэрхийлэхэд хэцүү бодол санаа буюу мэдрэмжийг илэрхийлэхэд дуу хөгжим бидэнд тусалдаг” (Заах удирдамж [2001], 10).

Асуултууд асуу:

Хүүхдүүдийг хичээлд идэвхтэй оролцуулах асуултуудыг асуу. Асуултууд нь хүүхдийн анхаарлыг төвлөрүүлж, сайн мэдээний зарчмуудын тухай ойлголтыг нь нэмэгдүүлэхэд тусална (ХДН 300-ыг үз). Хүүхдүүд дуулах явцдаа хариуг нь олж чадах тийм байдлаар асуултуудыг асуухаа сана.

Хүүхдийн Хэсэгт дуу хөгжмийг хэрхэн ашиглах тухай

Хүүхдийн Хэсэгт дуу хөгжмийг ашиглахын зорилго нь Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүдэд заах, сайн мэдээний дагуу амьдрахад нь тэдэнд туслах явдал юм. Хүүхдийн Хэсгийн дуунууд нь суралцах үйл явцыг илүү таатай болгож, хүүхдүүдэд сайн мэдээний үнэнийг сурч, санахад нь тусалж, Сүнсийг тэдэнтэй хамт байлгадаг.

Дуу хөгжмөөр дамжуулан сайн мэдээг хүүхдүүдэд заахад тань туслах зарим аргыг доор харуулав. Жишээнүүд нь энэ хөтөлбөрт санал болгосон дуунууд дээр ажиллахад тань туслах болно. Нэмэгдэл санаануудыг 2010, 2011 оны хөтөлбөр дэх “Хүүхдийн Хэсэгт дуу хөгжмийг хэрхэн ашиглах тухай” хэсгээс харна уу.

Дуу хөгжмөөр дамжуулан сайн мэдээг заа

Хүүхдийн Хэсгийн хамгийн үр өгөөжтэй зарим хичээлийг дуу хөгжим ашиглан заадаг. “Дуу хөгжим нь хүүхдүүдийн сайн мэдээний зарчмуудын тухай ойлголтыг нэмэгдүүлж, тэдний гэрчлэлийг бэхжүүлдэг” (TNGC, 174). Дууны утгыг ойлгоход нь хүүхдүүдэд туслах асуултуудыг асуу. Жишээ нь, “Зөвийг сонго” (Hymns, no. 239) дуулал нь бид шийдвэр гаргахад ганцаархнаа байдаггүй, зөв сонголт хийхэд Ариун Сүнс биднийг удирдах болно гэдгийг заадаг. Самбар дээр ЗС гурван бамбай зурж, дотор нь дараах асуултуудыг бич: “Зөвийг сонгоход намайг хэн удирдах вэ?” “Тусламж хэзээ надад гэрэлтэн харагдах вэ?”

“Намайг зөвийг сонгоход юу амлагдсан бэ?” Нэг дэх бамбай уруу заагаад асуултыг бүгдээрээ уншаад, дууг дуулахад хүүхдүүдийг чагнаж, хариуг сонссон үедээ босохыг хүс. Хариултыг өөртэйгөө хамт тэднээр хэд хэдэн удаа дуулуул. Энэ нь үгийг хөгжмийн аятай тохируулахад тэдэнд тусална. Энэ мэтээр бусад асуултууд дээр ажилла. Хүүхдүүдэд ойлгоход хэцүү байж болох үгс буюу өгүүлбэрийг ярилц. Дууг бүхэлд нь дуулсны дараа энэ дууг дуулахын хамт бид анхааран сонсож, зөв сонголт хийх юм бол Ариун Сүнс биднийг удирдах болно гэдгийг хүүхдүүдэд сануул.

Дуу хөгжмийн үйл ажиллагаанд бүх хүүхдийг оролцуул

Бүх насны хүүхдүүд дуу хөгжимтэй үйл ажиллагаанд оролцох дуртай байдаг. Дууны хэмнэл нь тэд юуны тухай дуулж байгаа болон дууны үгсийн утгыг санахад хүүхдүүдэд тусалдаг. “Үнэний төлөө зогс” (CS, 159) дууг дуулахдаа хурд, дууны чанга сул нь өөрчлөгддөгийг анхаар. *Лигато* (удаан бөгөөд жигд), *стаккато* (түргэн бөгөөд цохилтгой) зэрэг хөгжийн нэр томьёог зааж, хүүхдүүдийг энэ хоёр аргаар хоёулангаар нь дуулж сургахад анхаарна уу.

Хүүхдүүд бас алгаа таших, гараараа үйлдэл үзүүлэх зэрэг янз бүрийн хөдөлгөөн үзүүлж дуулах дуртай байдаг. “Мэргэн хүн, мунхаг хүн хоёр” (ХДН) дуунд гараар хийж үзүүлэх хөдөлгөөн нь дууны үгс дээр анхаарал төвлөрүүлэхэд хүүхдүүдэд тусална. Та бас “Нифайн зориг” (CS, 120–121) дууг дуулахад хөдөлгөөн хийж болно. Жишээ нь, хүүхдүүд “Би явна” гэж дуулахдаа нэг гараараа бамбайг өргөж, “Их Эзэний зарлигласныг хийнэ” гэж дуулахдаа толгой дээгүүрээ илд өргөж үзүүлэн, “Их Эзэн арга



замыг бэлтгэдэг, Түүнийг дагахыг хүсдэг” гэж дуулахдаа дорoo алхахыг хүүхдүүдээс хүс. Аль нэг дууг дуулахад хүүхдүүд өөрсдөө санаачлан

хөдөлгөөн үзүүлэхийг хүс (харин ариун ёслолын танилцуулгын үед дуулахдаа хөдөлгөөн хийх нь зохимжгүй юм).



Зөвлөгөө: Хүүхдийн Хэсэгт дуулдаг дуунуудаа гэр бүлийн үдэш дээр, судар судлах болон бусад тохиромжтой цагаар дуулахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Сайн мэдээний зарчмуудыг бататгахад дуунуудыг ашигла

Дуу заахдаа хүүхдүүдийг сайн суртал нь олон дахин давтан дуулах хэрэгтэй. Мөн дуунуудыг хүүхдүүдийн ой тоонд ортол нь жилийн турш давтан дуулж байх хэрэгтэй. Дууг заасны дараа янз бүрийн хөгжилтэй хэлбэрээр давтан дуулж бай. Хүүхдүүд дуунуудыг сайн санаж байхын тулд хүүхдийн ариун ёслол дээрх танилцуулгын дараа ч дуунуудыг дахин давтан дуулсаар байх хэрэгтэй. Янз бүрийн зүйлс ашиглан хүүхдүүд давтах хэрэгтэй гэж үзсэн дуунуудын жагсаалтыг гаргаж болно (жишээ нь, ваартай цэцэг, аквариум дахь цаасан загас, цацагт хяруулын өд, модны навч, ангийн хананд байрлуулсан зүрхний зураг). Нэг удаа нэг зүйлийг сонгон, холбогдох дууг дуулахыг хүүхдүүдээс хүс. Дууг хэрхэн давтах тухай зарим нэмэлт санааг доор өгөв (үзүүлэнгүүдийг sharingtime.lds.org-аас үзэж болно):



- **Хүүхэлдэй ашиглан дуулах нь** Бага насны хүүхдийн гарын авлага, **Бяцхан үрсээ анхаар** хуудас 63 дээрх зургуудаас нэгийг хүүхэд бүрээр будуулахаар хувилж, хайчилж ав. Хүүхэлдэй хийхийн тулд зураг бүрийг цаасан уутан дээр наа. Хүүхэлдэйтэйгээ хамт дуулахыг хүүхдүүдээс хүс.



- **Шоо хаяж дуулах нь** Тал бүр дээр нь өөр өөр хөдөлгөөнийг бичсэн шоо хий. Хүүхдүүд дуулахдаа ямар хөдөлгөөн хийхийг мэдэхийн тулд нэг хүүхдээр шоог хаяул.



- **Сагс уруу шид:** Хүүхдүүдийн нэгийг нь тоглоомон бөмбөг буюу базаж бөөрөнхийлсөн цаасыг сагс уруу шидэхийг хүс. Хэрэв хүүхэд анхны шидэлтээрээ сагсанд оруулбал хүүхдүүдээр дууны бадгийг нэг удаа дуулуул, хоёр удаа шидэж оруулсан бол бадгийг хоёр удаа дуулуул гэх мэтчилэн цааш үргэлжлүүл.



- **Охид дуулна/Хөвгүүд дуулна:** Нэг эрэгтэй хүүхдийн зураг, нэг охины зургийг өөр өөр савхан дээр наа. Дууг давтаж байх үед хэн дуулахыг харуулсан зургийг соль. Ингэх нь хүүхдүүдийг хичээлд идэвхтэй оролцоход тусална.





Бурханы хүүхэд болохоор

Баяртайгаар ♩ = 96-108

Үг, аяыг Жэнис Кэпп Перри

1. Би бу - руу зө - вийг сон - гож чад - на. Зөв
 2. Гэр бүл минь хай - раар бял - хах тул би их
 3. Би аав ээж, ах дүү - дээ тус - алж байя. Би

сон голт нь гэр бүл - ийг минь а - дисал - даг.
 аз жар - гал - тай, а - мар ам - га - лан байна. А -
 сайн үйл - сээр - ээ тэд - нийг ба - яр - луулж байя.

риун Сүнс на - дад зөв зүй - лийг заа - даг, Энэ

онц - гой гэр - лийг Бур - хан - аас би ав - даг.

© 2006 Жэнис Кэпп Перри, Зохиогч. Бүх эрх хамгаалагдсан.
 Энэ дууг ашгийн бус зорилгоор гэрт болон сүм дээр ашиглахаар хуулбарлан олшируулж болно.
 Энэ анхааруулгыг олшируулсан хуулбар бүрд бичих ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд заах нь

“Бүх хүүхдүүд чинь Их Эзэнээр сургагдах болно; мөн хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно” (3 Нифай 22:13) гэж Аврагч заасан билээ.

Хүүхдийн Хэсгийн удирдагчид бүх хүүхдүүдэд түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ч гэсэн Есүс Христийн сайн мэдээг заах чухал үүрэг хариуцлагатай юм. Хүүхдийн Хэсэг нь хүүхэд бүрийг халуун дотноор угтан, хайрлах, арчлах, хамруулах газар мөн. Ийм уур амьсгалд хүүхдүүд Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христийн хайрыг ойлгож, мэдрэхэд хялбар бөгөөд Ариун сүнсний нөлөөг илүүтэй мэдрдэг.




Хүүхэд бүр Бурханд үнэ цэнэтэй. Хүүхэд бүрд хайр, хүндлэл, дэмжлэг хэрэгтэй.

Хүүхдийн Хэсгийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээг хангахад бусдын зөвлөмжийг ав.

- 1. Хүүхдийн эцэг эхтэй зөвлөлд.** Эцэг эхчүүд хүүхдээ хэнээс ч илүү мэддэг. Хүүхдийнхээ хэрэгцээ, анхааралыг нь татах, суралцах сайн аргаар хэрхэн хангахыг тэд та нарт заах болно. Жишээ нь, зарим хүүхдүүд зааж байгаа зүйлийг дуу хөгжмөөр, бусад нь түүх, зураг, судар эсвэл хөдөлгөөнөөр илүү сайн сурдаг. Хүүхэд бүрд сайн суралцах арга замуудыг эзэмшүүлэхэд чиглэсэн олон янзын заах арга зүйг ашигла.
- 2. Хүүхдийн Хэсгийн бусад удирдагчид, багш нартай зөвлө.** Хүүхэд бүр Есүс Христийн сайн мэдээнд суралцаж, хайрыг мэдрэх арга замуудыг олохын төлөө залбир, хамтран ажилла.
- 3. Тойргийн зөвлөлтэй зөвлөлд.** Санваартны болон бусад туслах бүлгүүдийн удирдагчид онцгой анхаарал шаардлагатай хүүхдүүдэд хэрхэн туслах талаар янз бүрийн санааг мэддэг байж болно. Нэг тойрогт дээд пристийн бүлэг зожиг зантай хүүхдэд туслан анхаарал тавьж, долоо хоног бүр дэргэд нь суух

“Хүүхдийн Хэсгийн өвөөг” санал болгосон байна. (Тэр хүн долоо хоног бүр ирж хичээл дээр сууж болно.) Энэ нь хөвгүүн хичээлдээ анхаарлаа төвлөрүүлж, хайрыг мэдрэхэд тусална.

Ахлагч М.Расселл Баллард, “Эрхэм үнэт хүүхдүүдтэй ажиллах хүмүүст ариун, уужим сэтгэлтэй үйлчлэгч байх үүрэг хариуцлага оногдуулсан нь ойлгомжтой. Бурхан өнөөгийн хүүхдүүдийг хайраар, итгэлийн гал дөлөөр, тэд хэн бэ гэдгээ мэдэх ойлголтоор дүүрэн байлгахын тулд биднийг томилсон юм” (“Great Shall Be the Peace of Thy Children,” *Ensign*, 1994 оны 4-р сар, 60) гэж заажээ.



Дүрснүүдийг sharingtime.lds.org -аас авч болно.

Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд хэрхэн туслах тухай **НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙГ** Teaching, No Greater Call, 38–39-р хуудсаас болон disabilities.lds.org-aac үзнэ үү.

Хөгжлийн бэрхшээлтэй зарим хүүхдүүд үзүүлэнд сайн хариулдаг. Залбирал хийх, чимээгүй болох эсвэл дуу дуулах цаг болоход энд харуулсантай адил дүртэй үзүүлэнгүүдийг ашигла.

Хичээлийг хялбаршуулан заах нь:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ангид хуваалцах цагаа тэдэнд зориулан хялбаршуулах хэрэгтэй байж болно. Хичээлийг хялбаршуулан заах тухай зарим жишээг sharingtime.lds.org -аас үзэж болно.





ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

